

SUSTAINABLE


Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн сэтгүүл 2023 он 01 (02)



**Хүртээмжтэй байдлын үүднээс хүн бүрт
ҮНЭГҮЙ тараагдана.**



SUSTAINABLE DEVELOPMENT GOALS





MICC-ийн тухай

MICC нь 2005 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Монголын анхны бүрэн хэмжээний санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хөрөнгө оруулалтын компани юм. Байгуулагдсан цагаасаа хойш бид харилцагчдадаа 1.5 тэрбум гаруй ам.доллар босгож, 100 гаруй хэлцлүүдийг амжилттай хийж, харилцагчдын бизнесийг өргөжүүлэн, илүү хямд хөрөнгө оруулалтын эх үүсвэр олох, компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд нь тусалж байна.



Хөрөнгө оруулалтын зөвлөх



Брокерын үйлчилгээ



Судалгаа

2023 онд Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдсан дараах төслүүдэд санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажиллаа.

17 хөгжлийн төлөөх
түншлэлийг
бэхжүүлэх



8 эдийн засгийн өсөлт,
зохистой хөдөлмөрийг
дэмжих



7 сиргэлдэх эрчим
хүчийг нэвтрүүлэх



12 хариуцлагатай
үйлдвэрлэл,
хэрэглээг дэмжих



\$ 1,600,000,000

Хөрөнгө оруулалтын
хэлэлцээр
Зөвлөх



МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

₮ 345,900,000,000

Бондын санхүүжилт
Санхүүгийн зөвлөх



DSP
DESERT SOLAR POWER

\$ 10,000,000

Ногоон санхүүжилт
Санхүүгийн зөвлөх

GEM TRADE

₮ 28,000,000,000

Бондын санхүүжилт
Андеррайтер

Холбоо барих:

TRUSTED INVESTMENT ADVISER



www.micc.mn



7011-2023



contact@micc.mn



7 давхар, Жи Жи Тауэр, Явуухулангийн
цэцэрлэг, Улаанбаатар хот 15170, Монгол Улс

АГУУЛГА

06

ТӨВ АЗИ БА ЗҮҮН АЗИЙН НИЙСЛЭЛ ХОТУУДЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС

МСС Судалгааны баг Зүүн хойд Ази, Төв Азийн нийслэл 7 хотын тогтвортой хөгжлийн төлөв байдлыг тоон аргаар судалж, НҮБ-ын 2030 оны зорилгод нийцүүлэн "индекс"-жүүлэн харьцуулав.

14

ХОТУУДЫН АМЬДРАЛЫН ӨРТӨГ

Амьдралын өртгийн долоон хотын харьцуулалтыг танилцуулж байна.

16

Б.ГАНТҮЛХҮҮР: Аз жаргалтай, баяр баясалтай ажлын орчныг мэдрүүлэх үүднээс ногоон барилгын ажлыг эхлүүлсэн



26

ХОТЫН ЗАЛУУС БА ВИНТЭЖ СОЁЛ



Ээж, эгчийнхээ хуучин хувцсыг өмсөхдөө хэнээс ч ичихгүй, юунаас ч санаа зовохгүйгээр "алив намайг хар даа, харцгаа" гээд гайхуулдаг үе иржээ.

38

ДУГУЙЧДАД ХҮЛЭЭЦТЭЙ ХАНДАЖ БАЙГААРАЙ

Машин замаар шахалдан явж байгаа унадаг дугуйтай хүмүүсийг хараад та дургүйцдэг үү? Хажууд нь бэлхэн дугуйн зам байсаар байхад машин замаар явлаа гэж та боддог уу? Тэгвэл энэ нийтлэлийг заавал уншаарай.

50

ХОТЫН ҮЗЭГДЭХ ОРЧНЫ БОХИРДОЛ

Төрөл бүрийн зар сурталчилгаа, үзэмжгүй унжсан кабель утаснууд зэрэг нь дэлхийн томоохон хотуудад түгээмэл зонхилж буй үзэгдэх орчныг бохирдуулж буй зүйлс юм.

РЕДАКЦИЙН ЗУРВАС

М ICC-ийн судалгааны баг зах зээлийн болон хувьцааны судалгааг тогтмол хийхээс гадна нийгэм, эдийн засгийн салбарт тулгамдаж буй нэг асуудлыг сонгон авч, жил бүр сэдэвчилсэн судалгаа хийж, олон нийтийн хүртээл болгож ирлээ.

Өнгөрсөн жилд буюу 2022 онд “Улаанбаатар хотын агаарын бохирдлын эдийн засагт учруулж буй шууд болон шууд бус зардлын судалгаа”-г хийж, судалгааны үр дүнг “Sustainable” сэтгүүлийн эхний дугаарт танилцуулж байв.

Энэ удаад “Тогтвортой хотууд” сэдвийн хүрээнд сэтгүүлийн хоёр дахь дугаараа та бүхэнд хүргэж байна.

Дэлхийн хүн амын талаас илүү хувь нь амьдардаг өнөө цаг үеийн хотууд нь эдийн засгийн төвлөрсөн хүч болж, дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 80 гаруй хувийг бүрдүүлж байна.

Түүнчлэн хотууд нь дэлхийн гадаргуугийн 2 хүрэхгүй хувийг эзэлдэг ч дэлхийн эрчим хүчний 78 хувийг хэрэглэж, хүлэмжийн хийн ялгарлын 60 гаруй хувийг бүрдүүлж буй нь уур амьсгалын өөрчлөлтөд тодорхой хэмжээгээр нөлөөлсөөр байна. Иймд 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн зорилгуудыг зорилтот түвшинд хүргэхэд хотууд чухал үүрэгтэй юм.

MICC Судалгааны баг нь Улаанбаатар, Ташкент, Бишкек, Бээжин, Астана, Сөүл, Токио хотыг нээлттэй өгөгдөл мэдээлэлд тулгуурлан судалсан судалгааны үр дүнг хуваалцаж байгаадаа баяртай байна.

Хотуудыг тогтвортой хөгжлийн үзүүлэлтээр эрэмбэлэн судлах судалгааг АНУ болон Европын зарим хотуудын жишээн дээр сүүлийн жилүүдэд тогтмол хийж ирсэн боловч Азийн хотуудын хувьд энэ төрлийн судалгаа төдийлөн хийгдээгүйг онцлох нь зүйтэй болов уу. Хот бол тухайн улсын түүх, соёл, эдийн засаг, худалдаа, бизнесийн орчны гол хурдасгагч нь юм.

Тэгвэл Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотыг анх хэрхэн төлөвлөж байсан болон нийслэл хотоо ээлтэй хот болгох чиглэлд салбар бүрийн залуус хэрхэн оролцож, хувь нэмрээ оруулж буй талаар сэтгүүлийн шинэ дугаараас танилцарай.



Дугаар эрхлэгч
Н.ЭНХЗУЛ

SUSTAINABLE

Эрхлэн гаргагч:
Sustainable Development
Solution Network LLC

MICC LLC

Редакцийн зөвлөл:
Н.Энхзул
Н.Ариунтуяа
Э.Мишээл
Д.Хулан

Зочин нийтлэлчид:
Б.Золзаяа
Э.Минжмаа
О.Удвал

Дүрслэл зураг
illustration art: Apolla art

Sustainable сэтгүүлийг эрхлэн гаргах эрхийг SDSN эзэмшдэг. Сэтгүүлийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Сэтгүүлийн эх материалуудыг редакцийн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр дахин хэвлэх, хайлтын системд байршуулах, цахим, механик, фото хуулбар зэрэг ямар ч хэлбэрээр хувилж олшруулах, түгээн тараахыг хатуу хориглоно.



Хавтасны зураг: С.Биндэрьяа

**БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН
ЗАСГИЙН СЭТГҮҮЛ**

Эрхлэн гаргагч: Эс.Ди.Эс.Эн.ХХК
MICC

Хаяг: 7 давхар Жи Жи Тауэр, Явуухулангийн
цэцэрлэг, Улаанбаатар хот 15170, Монгол Улс

Холбоо барих:
7011-2023, contact@micc.mn



МИСС Тогтвортой хотуудын
судалгаанд оролцсон:



О.Баттулга нь тогтвортой хөгжлийн судалгааныхаа дэлгэрэнгүй тайланг ойрын хугацаанд хэвлүүлэхээр төлөвлөж байна. АНУ-ын Вашингтон хот дахь Эрчим хүчний бодлогын судалгааны хүрээлэнгээр дамжуулан яамд, шийдвэр гаргагчид, бизнесийн байгууллагуудад эрчим хүчний бодлогын зөвлөмж өгдөг. Жонс Хопкинсийн их сургуулийн Ахисан түвшний олон улс судлалын сургуулийг эрчим хүч, эрдэс, хүрээлэн буй орчны магистрийн зэрэгтэй төгссөн.



Н.Энхзул нь "Sustainable Mongol" подкастаараа дамжуулж Тогтвортой хөгжил-байгаль орчны сэдвүүдээр 100 гаруй дугаар бэлтгэн олон нийтийн ойлголт мэдлэг, мэдээллийг сайжруулах чиглэлд хувь нэмрээ оруулсаар байна. Сүүлийн жилүүдэд арилжааны банк болон хөрөнгө оруулалтын салбарт ногоон санхүүжилт, БОНЗ-ын шинжээчээр ажиллаж байна.



Б.Мөнхзул нь "Impact investment" чиглэлээр 7 жил ажилласан туршлагатай бөгөөд Монгол Улсын эдийн засгийн гол салбарын ЖДБ, ТӨХК болон томоохон корпорациудад олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөрөнгө оруулалт босгож байсан. Одоогоор уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг технологи хөгжүүлэлтийн салбарт ажиллаж байна.

Тогтвортой хотуудын судалгааны өгөгдөл мэдээлэл цуглуулах багт ажилласан Х.Мөнхзул, Т.Марал, Б.Ангараг, Х.Алтанчимэг нарт талархал илэрхийлье.

ТӨВ АЗИ БА ЗҮҮН АЗИЙН НИЙСЛЭЛ ХОТУУДЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС

СУДАЛГААНЫ ТОЙМ:

2030

2015 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-аас 2030 онд хүрэх Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ыг тунхагласнаас хойш хугацааны тэн хагас өнгөрөөд байна. Иймээс тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилт ямар ахиц гарч байгааг улс орнуудаар, тэр дундаа хотуудын түвшинд үнэлэхийн тулд 17 зорилгоос хотын түвшинд хамааралтай 8 зорилгын хүрээнд эл судалгааг хийлээ.

Азийн 7 нийслэл хот

МИСС Судалгааны баг 2022 оны үзүүлэлтээр Зүүн хойд Ази, Төв Азийн 7 нийслэл хотын тогтвортой хөгжлийн төлөв байдлыг тоон аргаар судалж, НҮБ-ын 2030 оны зорилгод нийцүүлэн "индекс"-жүүлэн харьцуулав. Судалгааны хүрээнд авч үзсэн 8 зорилгын үзүүлэлтээр сонгосон 7 хот нь үндсэн 100 онооноос 55.5-87.4 оноо авсан байна.

55.5 - 87.4 оноо

Токио хот (87.4) оноо авч 7 хотыг тэргүүлсэн бол Улаанбаатар хот (55.5) оноогоор хамгийн сүүлийн байранд орж байна. Улаанбаатар хотын хувьд хамгийн өндөр оноог "жендэрийн эрх, тэгш байдлыг хангах" зорилго дээр (72.9) авсан бол "эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байраар хангах" зорилго хамгийн хамгийн бага (34.9) оноо авчээ. (График 1)

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО ЯМАР ТҮВШИНД БАЙНА ВЭ?

Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-ын үргэлжлэл болгон НҮБ-аас баталсан ТХЗ нь “нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхий нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг” юм¹. ТХЗ нь 17 үндсэн зорилго, тэдгээрийг дагалдах олон зорилт, үзүүлэлттэй. Эдийн засагч Жеффри Саксын үзснээр 17 зорилгыг эдийн засаг, нийгэм, байгаль орчин гэсэн 3 үндсэн хэсэгт хувааж болох ч “сайн засаглал” гэсэн 4 дэх хэсэггүйгээр үндсэн 3 хэсэг амжилтад хүрэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл өргөн цар хүрээтэй хөгжлийн зорилгод

хүрэхэд Засгийн газруудын оновчтой бодлого, тэдгээрийг дагасан нийгмийн суурь үйлчилгээ зайлшгүй шаардлагатай.


Тогтвортой хөгжил нь хүний хөгжилтэй салшгүй холбоотой. Жеффри Сакс нарын боловсруулсан Тогтвортой хөгжлийн индекс (17 зорилгын 244 үзүүлэлт/индикатор) нь Хүний хөгжлийн индекс (ХХИ) наслалт, боловсрол, үндэсний нийт бүтээгдэхүүн гэсэн 3 үндсэн үзүүлэлт/индикатортай өндөр харилцан хамаарал (корреляц)-тай байна.

График 2-т үзүүлснээр Ази тив нь дэлхийн хүн амын 60 хувийг бүрдүүлдгийн хувьд дээрх хоёр индексээр хөгжлийн

олон түвшинд хамаарах улсуудаас бүрддэг. Тухайлбал, хөгжингүй (Япон, Өмнөд Солонгос, Катар), пост-коммунист/коммунизмын дараах шилжилтийн (Монгол, “стан”-ы улсууд), хамгийн их хүн амтай (Хятад, Энэтхэг) болон нэн ядуу (Афганистан, Йемен) улс энэ тивд оршиж байна.

2015 оноос хойш улс орнуудын Засгийн газрууд болон иргэний нийгмийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд ТХЗ-д хүрэх шат дараатай олон алхам авч хэрэгжүүлсээр байна. Гэвч гаргаж буй хүчин чармайлт харилцан адилгүйгээс гадна өдийг хүртэлх ололт амжилт нь

НҮБ-ын гишүүн орнуудын ТХЗ-ын индекс ба ХХИ оноо (2020/2021)



Эх сурвалж: MICS Тогтвортой хотуудын судалгаа-2022



2030 оны зорилгод хүрэхэд хангалттай бус байна. 2022 оны Тогтвортой хөгжлийн тайланд дурдсанаар 2019-2021 онд ТХЗ-ын хүрээнд ямар ч ахиц дэвшил гараагүй байна.

Тогтвортой хөгжлийн түвшин зогсонги байдалд орсон нь судалгаанд хамрагдсан

7 нийслэл хотын 7 улсад үлэмж хамааралтай юм. Зүүн хойд, Төв Азийн эдгээр 7 улсын ТХЗ-ын дундаж индекс оноо 2015-2019 онд 1.5-аар нэмэгдсэн бол дараагийн 2 жилд бараг тэгтэй тэнцүү байв (График 3). Анхаарал татсан бас нэг зүйл нь эдгээр улсад гарсан тогтвортой

хөгжлийн ахиц дэвшил ихээхэн ялгаатай. Тухайлбал, Узбекистан улсын тогтвортой хөгжил 2015-2021 онд 4 орчим индекс оноогоор нэмэгдсэн байхад Монгол Улсынх бараг өсөөгүй байна.

ЯАГААД ЭНЭ СУДАЛГААГ ХИЙХ БОЛОВ?

Ази тивийн тогтвортой хөгжилд өсөн нэмэгдэж буй хүн ам, хурдацтай тэлж буй хотжилт нь хотуудын гүйцэтгэх үүрэг нөлөөг улам бүр нэмэгдүүлж байна. Дэлхийн бусад бүстэй харьцуулахад Ази тивд хотын хүн ам хамгийн хурдацтай өсөж байна. НҮБ-ын таамаглалаар Азийн хотжилтын түвшин 2015 онд 48 хувь байсан бол 2030 онд 56.7 хувь болж өсөх


ажээ². Тус тооцоогоор Монгол Улсын хотод амьдардаг хүн амын тоо 68.2 хувиас 70.6 хувьд хүрэх юм.

Хүн амын дийлэнх нь аж төрж буй Азийн хотуудад эрүүл мэнд, эрчим хүч, хүний эрх, засаглал болон эдийн засагт тулгарч буй асуудлууд нь ТХЗ-д хүрэхэд гол бэрхшээл учруулж байна. Үүнийг даван туулахын тулд хотууд харилцан туршлага

солилцох, хөгжлийн түвшний харьцуулалт хийх нь чухал ач холбогдолтой.

MICC Судалгааны баг Зүүн хойд Ази, Төв Азийн 7 хотод тогтвортой хөгжлийн түвшин болон 2030 оны зорилгод хүрэхэд ямар саад бэрхшээл тулгарч байгааг судалсан бөгөөд судалгааны дэлгэрэнгүй тайланг ойрын хугацаанд танилцуулна.

MICC-ийн судалгаанд хамрагдсан 7 хотын ТХЗ-ын индекс оноо




Индикатор буюу үзүүлэлтийн тодорхойлолт нь "аливаа салбарт аливаа улсын эзлэх байрыг тодорхойлохуйц фактад үндэслэн гаргасан тоон эсхүл утган хэмжигдэхүүн." OECD (2008). Handbook on Constructing Composite Indicators: Methodology and User Guide. P.13. <https://www.oecd.org/sdd/42495745.pdf>

Тогтвортой хөгжлийг хэмжихэд “нийлмэл үзүүлэлт”-ийг яагаад ашигладаг вэ?

Тогтвортой хөгжлийн 17 зорилго хоорондоо уялдаа холбоотой учир тэдгээрийг бүхэлд нь хэмжих шаардлагатай. Дундаж наслалт (ж: 80 нас), бичиг үсэг тайлагдалт (ж: 85%) зэрэг тэс ондоо хэмжих нэгжтэй үзүүлэлтүүдийг 0-100 индекс оноо гэсэн нийтлэг нэгжид хувиргаснаар ТХЗ-ын олон үзүүлэлтийг

нэгтгэн үнэлэх боломжтой болж байгаа юм. Ингэж ТХЗ-ын хэрэгжилтийг салбар, улс, цаг хугацаа дамнан харьцуулснаар хөгжлийн мэргэжилтнүүд, шийдвэр гаргагчид төдийгүй энгийн иргэдэд ойлгомжтой мэдээллийг композит индексээр дамжуулан өгч болдог.

ТХЗ индекс онооны өсөлт (2015 он = 0)



Эх сурвалж: МИСС, Тогтвортой хөгжлийн тайлан-2022

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

МИСС Судалгааны баг нь нийслэл хотуудын тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүд (индикатор)³-ийг 0-100 оноо бүхий “композит индекс” буюу “нийлмэл үзүүлэлт”-д хувирган харьцуулсан. Ингэхдээ АНУ болон Европт ашиглагддаг төстэй судалгааны арга зүйг ашиглав. Мөн индекс бүтээхэд ашигласан үзүүлэлтүүдийг НҮБ-ын албан ёсны баримт бичиг болон Тогтвортой хөгжлийн бусад судалгаанаас авсан. Үзүүлэлтийг сонгохдоо өгөгдлийн шинэлэг байдал (2020-2021 он), өгөгдлийн хамрах хүрээ (судалсан хотуудын ядаж 80 хувийг

хамарч байх) гэсэн хоёр шалгуур тавив. Багагүй хугацаанд тоо баримт цуглуулж, тэдгээр мэдээлэлд дүн шинжилгээ хийсний эцэст дээрх шалгуурыг хангах 8 зорилгыг судалгаанд оруулсан.

Судалгааны тоо баримтыг олон хэл дээрх үндэсний болон орон нутгийн (нийслэлийн) статистикийн агентлагуудын өгөгдлийн сангууд, мөн НҮБ, Дэлхийн банк тэргүүтэй нэр хүндтэй байгууллагуудаас авч ашигласан. Шаардлагатай тохиолдолд зарим дам эх үүсвэр, гуравдагч байгууллагын индексийг хэрэглэв.

Индексийн 0-100 оноог тогтоохын тулд

дээд, доод хүрээг заасан. 100 индекс оноо нь дээд хүрээг илтгэх бөгөөд тухайн үзүүлэлтийн (ж: бичиг үсэг тайлагдалт) хамгийн өндөр боломжит тоо/хувь (ж: хүн амын 100 хувь бичиг үсэг тайлагдалт)-ийг илэрхийлнэ.

Хамгийн өндөр тоо/хувийг тогтоох боломжгүй үед тухайн үзүүлэлтээр дэлхийд тэргүүлэх 5 улсын дунджийг ашиглав. Харин 0 индекс оноо нь доод хүрээ бөгөөд боломжит хамгийн бага тоо/хувь эсхүл доод 2.5 процентилийн утгыг төлөөлнө.

Үүнд орох гол баримт бичиг бол НҮБ-ын Transforming Our World: The 2030 Agenda for Sustainable Development. <https://sdgs.un.org/2030agenda>
Бодит ДНБ нь худалдан авах чадварын паритетаар илэрхийлсэн доллар юм. Ингэхдээ ДНБ-ийг цаг хугацаа дамнан харьцуулах үүднээс 2017 оны олон улсын доллар (international dollar)-аар илэрхийлэв. Худалдан авах чадварын паритетаар илэрхийлсэн 2017 оны олон улсын доллар нь 2017 оны нэрлэсэн америк доллартай ижил үнэ цэнтэй.



MICC Тогтвортой хөгжлийн индекс: Зүүн хойд, Төв Азийн хотууд

	3 ЭРХЭН ХӨГЖЛЭГ ДЭНЖЭГ	4 ЧАМРЫН БЭЛЭВЧЛЭЛЭЙ ДЭНЖЭГ	5 ИХЭЭНХЭЙ ЭНГ ТӨГӨ АМЛАДЫГ ХӨГЖЭГ	6 БАКАЛАЙН РОДЫН ГС ЭНГЭРЭГЭЙН ХӨГЖЛӨЛӨӨН ДЭНЖЭГ	7 СОНГОХ ЭНГЭРЭГЭЙН ХӨГЖЛӨЛӨӨН ДЭНЖЭГ	8 ХӨГЖИЛ СЭХЭЙН ХӨГЖЛӨЛӨӨН ДЭНЖЭГ	11 СОНГОХ ЭНГЭРЭГЭЙН ХӨГЖЛӨЛӨӨН ДЭНЖЭГ	16 ӨНГ ТАВАН АНДРАГДЛАХ ХӨГЖЛӨЛӨӨН ДЭНЖЭГ	Дундаж оноо
Улаанбаатар	64.8	47.4	72.9	61.6	59.4	34.9	49.1	53.7	55.5
Ташкент	69.2	55.3	76.3	96.2	92.4	36.6	49.0	54.3	62.5
Бишкек	67.1	53.6	60.9	96.6	69.3	34.6	60.7	57.0	66.2
Бээжин	87.0	92.9	74.0	97.5	82.2	59.4	65.9	69.6	78.6
Астана	68.8	87.1	76.6	98.4	74.2	83.7	80.0	62.5	78.9
Сеул	85.1	92.3	74.7	100.0	85.5	83.3	67.7	80.0	83.7
Токио	89.5	93.8	67.6	100.0	86.4	89.1	85.1	87.9	87.4


Хүснэгт 1

Улаанбаатар хотын ТХЗ-ын оноог бусад 6 хоттой харьцуулахад

	3 ЭРХЭН ХӨГЖЛЭГ ДЭНЖЭГ	4 ЧАМРЫН БЭЛЭВЧЛЭЛЭЙ ДЭНЖЭГ	5 ИХЭЭНХЭЙ ЭНГ ТӨГӨ АМЛАДЫГ ХӨГЖЭГ	6 БАКАЛАЙН РОДЫН ГС ЭНГЭРЭГЭЙН ХӨГЖЛӨЛӨӨН ДЭНЖЭГ	7 СОНГОХ ЭНГЭРЭГЭЙН ХӨГЖЛӨЛӨӨН ДЭНЖЭГ	8 ХӨГЖИЛ СЭХЭЙН ХӨГЖЛӨЛӨӨН ДЭНЖЭГ	11 СОНГОХ ЭНГЭРЭГЭЙН ХӨГЖЛӨЛӨӨН ДЭНЖЭГ	16 ӨНГ ТАВАН АНДРАГДЛАХ ХӨГЖЛӨЛӨӨН ДЭНЖЭГ	Дундаж оноо
Зүүн хойд Азийн 3 хот	87.2	93.0	72.1	99.2	84.7	77.3	72.9	79.4	
Төв Азийн 3 хот	68.4	65.3	71.3	97.0	78.6	51.7	63.2	58.0	
Улаанбаатар	64.8	47.4	72.9	61.6	59.4	34.9	49.1	53.7	
vs. ЗХ Ази	-22.4	-45.6	0.7	-37.6	-25.3	-42.4	-23.8	-25.7	
vs. Төв Ази	-3.6	-17.9	1.6	-35.5	-19.2	-16.8	-14.1	-4.2	

Хүснэгт 2

СУДАЛГААНД АШИГЛАСАН БУСАД СОНИРХОЛТОЙ ТОО БАРИМТЫГ ДООРХ ГРАФИКТ ҮЗҮҮЛЭВ




СУДАЛГААНД АШИГЛАСАН БУСАД СОНИРХОЛТОЙ ТОО БАРИМТЫГ ДООРХ ГРАФИКТ ҮЗҮҮЛЭВ.



Эмэгтэйчүүдийн манлайлал / төлөөлөл (2020-2022 он)

Эзлэх хувиар




© MICC



Цахилгаан холболт, сэргээгдэх эрчим хүч (2019 он)

Эзлэх хувиар




© MICC




СУДАЛГААНД АШИГЛАСАН БУСАД СОНИРХОЛТОЙ ТОО БАРИМТЫГ ДООРХ ГРАФИКТ ҮЗҮҮЛЭВ




Байрны үнэ
м2/нэг хүнд ногдох ДНБ



Агаарын бохирдол
Жилийн дундаж PM 2.5



Багш сурагчийн харьцаа
Бага боловсрол, нэг багшид ногдох



Улаанбаатар Токио Астана Ташкент
Бээжин Сөүл Бишкек

© MICS

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

MICS-ийн Тогтвортой хөгжлийн индексээр судалгаанд хамруулсан 7 нийслэлээс Токио хот үндсэн 100 онооноос 87.4 оноо авч тэргүүлсэн бол Улаанбаатар хот 55.5 оноогоор сүүлийн байранд оров (Хүснэгт 1).

- Хотуудын индекс оноо нь нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (НХН ДНБ)-ий бодит хэмжээ буюу эдийн засгийн хөгжилтэй эерэг хамааралтай байна. НХН ДНБ нь 2020 оны байдлаар 20 мянган ам.доллараас бага Бишкек (10.3 мянга), Ташкент (14.7 мянга), Улаанбаатар (16.5 мянга) хот 55.5-66.2 оноо авч сүүлийн гурван байранд орсон. 40-өөд мянган ам.долларын НХН ДНБ-тэй Астана (45.4 мянга), Бээжин (39.5 мянга) хот 3, 4 дүгээр байранд орж, харин 50 мянгаас дээш ам.долларын НХН ДНБ-тэй Токио (70.7 мянга), Сөүл (53.8 мянга) хот хамгийн өндөр оноо авчээ.

- Улаанбаатараас бусад хот ТХЗ 6 "Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламж"-аар дунджаар хамгийн өндөр буюу 98.1 оноо авсан нь дээрх хотуудад баталгаат ундны усны хангамж

зохистой түвшинд байгааг харуулж байна. Харин Улаанбаатар хот ариун цэврийн байгууламж дутмаг төдийгүй хүн амын 51 хувь нь баталгаат ундны усны хангамжгүй тул дөнгөж 61.6 оноо авсан.

- Ковид-19 цар тахлаас үүдэн ажилгүйдэл нэмэгдсэн нь ТХЗ 8 буюу "Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байр бий болгох" зорилгын оноог нийтэд нь доош татжээ. Бишкек, Ташкент, Улаанбаатарын орлогын түвшин хөгжингүй орныхоос 3-4 дахин бага байгаа нь энэ зорилго дээр авсан дундаж оноог бууруулахад мөн нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотын оноог Зүүн хойд Азийн 3 нийслэл хот (Бээжин, Сөүл, Токио), Төв Азийн 3 нийслэл хот (Астана, Бишкек, Ташкент)-ын дундажтай зарим салбарт харьцуулахад (Хүснэгт 2):

- ТХЗ 5 "Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах": Улаанбаатар илүү өндөр оноо авсан байна. Үүнд дээд боловсролын байгууллагад суралцагч эмэгтэйчүүдийн хувь (57.3), хувийн салбарт удирдах албан тушаалтны / менежерийн эзлэх хувь (51.8) зэрэг тоо эергээр нөлөөлсөн.

Гэвч төр засгийн байгууллагын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага, мөн эрэгтэй, эмэгтэй ажиллагдсын цалингийн зөрүү байсаар байна.

- ТХЗ 4 "Чанартай боловсролыг дэмжих": Улаанбаатарын хүн амын бичиг үсэгт тайлагдалт маш өндөр (99.5 хувь) хэдий ч боловсон хүчин, санхүүгийн дэмжлэг хомсдолтойгоос үүдэн ерөнхий болон дээд боловсролын чанар хангалтгүй байна. Жишээлбэл Улаанбаатарын бага ангийн нэг багшид ногдох суралцагчийн тоо (2020 онд 34.6) байгаа нь Ташкентынхаас 1.6 дахин, харин бусад хотынхоос бараг 2.5 дахин их байна.

- ТХЗ 16 "Энх тайван, шударга ёсыг цогцлоох": 2021 онд Монгол Улс "Трансперенси интернешнл" байгууллагын Авлигын индексээр Киргиз, Узбекистан улсаас 7-8 оноо илүү байсан ч 2022 онд энэ зөрүү 2-6 болж буурчээ. Мөн Улаанбаатар хотод санаатай хүн амины хэрэг 100 мянган хүн ам тутамд 7 байгаа нь галт зэвсгийн хямралгүй хотын хувьд тун өндөр үзүүлэлт юм (Бусад 6 хотод энэ тоо дунджаар 1.4 байна).



2025 ОНООС PFC ХИМИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭГ ХУУЛИАР ХОРЬЖ ЭХЭЛНЭ. ХАРИН FJÄLLRÄVEN 2015 ОНООС ХОЙШ АШИГЛААГҮЙ

FJÄLLRÄVEN БОЛ 100% PFC-FREE ҮЙЛДВЭРЛЭГЧ

PFC гэж юу вэ? PFC буюу фторокарбонат бол хүний гараар бүтээсэн химийн нэгдэл бөгөөд цахилгаан бараа, аяллын бараа, машин, нисэх онгоц зэрэг үйлдвэрлэлийн олон салбарт аливаа бүтээгдэхүүнийг хир толбо, усанд тэсвэртэй болгох зорилгоор ашигладаг. Энэ бодис нь байгаль орчин, хүн амьтанд хортой болох нь тогтоогдсон тул тус хотынхон үйлдвэрлэлдээ хэрэглэхгүй байхаар шийджээ. Fjällräven брэнд хүмүүсийг байгальд аялахыг уриалж, тав тухтай явахад нь тус болох бүтээгдэхүүн үйлдвэрлэж нэрд гарсан ч

энгийн, бат бөх загвартай өдөр тутмын Kånken үүргэвч нь тэдний нэрийг дэлхий дахинд таниулсан гол бүтээгдэхүүн юм. Үүсгэн байгуулагч Ake Nordin компани Шведийн сургуулийн насны хүүхдүүдийн мөрний ачааллыг тэнцүүлж, нурууны зовиургүй явахад нь тус болох үүднээс 1978 онд зохион бүтээсэн энэ цүнхийг та өнөөдөр хаанаас ч олж харж болно. Өдөр тутам үүрэх явцад элэгдэж урагдахгүйгээс гадна удаан хэрэглэх зориулалттай энэ үүргэвч чанарын хувьд Fjällräven-ы өгсөн амлалт ёсоор үе дамжин хэрэглэх эдэлгээтэй.

RE-KÅNKEN

Энэ бол хамгийн анхны туршилтын Kånken дахин боловсруулсан хуванцар 11 ширхэг савыг ашиглан энэхүү загварыг бүтээдэг билээ. Үүнээс гадна ус, эрчим хүч, химийн нэгдэл зэрэг байгалийн нөөцийг хамгийн багаар ашигладаг SpinDye@ технологиор өнгө оруулдаг юм.



KÅNKEN CLASSIC

Энэхүү загвар нь 43 жилийн турш өөрчлөгдөөгүй бөгөөд сая сая хүмүүсийн нурууг хамгаалж ирсэн хамгийн сонгодог загварын нэг гэгддэг. Энэхүү сонгодог загварын үүргэвч нь алхах, аялах болон ажил сургуульдаа ирэх, буцахдаа үүрэхийн аль алинд нь зохицсон. Материал нь бат бөх, хөнгөн Vinylon F загварын даавуу бөгөөд шороо, чийгийг тэсвэрлэх чадвартай.



Fjällräven Mongolia



arcticfoxmongolia

Хотуудын амьдралын өртөг

Судалгаанд хамрагдсан 7 хотын амьдралын өртгийг Heat Map зураглал дээр суурилан танилцуулж байна. Улаанбаатарт дундаж цалин бага байгаа ч өргөн хэрэглээний бүтээгдэхүүний харьцаа бусад 6 хоттой харьцуулахад ойролцоо дүнтэй байгааг Монгол төгрөгт шилжүүлэн харууллаа.

	УЛААНБААТАР	БИШКЕК
Удийн хоол	15,000	19,313
Ресторанд 2 хүний оройн хоол	100,000	71,457
Макдоналдстай дүйцэхүйц түргэн хоол	16,000	18,868
0.5 л шар айраг	5,950	3,863
Капучино кофе	7,956	6,769
Пепси / Кока кола, 0.5 л	2,709	2,148
Хотын төвд 40 м2 буюу 1 өрөө байрны түрээс	1,544,444	1,542,006
Хотын захад 1 өрөө байрны хямд түрээс	975,000	1,109,713
Хотын төвд 80 м2 буюу 3 өрөө байрны түрээс	3,750,000	2,797,867
Хотын захад 80 м2 буюу 3 өрөө байрны хямд түрээс	2,375,000	1,903,813
Орон сууцны урсгал зардал (цахилгаан, дулаан, ус, хог)	255,213	96,436
Дуудлага болон 10GB+ дата бүхий гар утасны сарын төлбөр	24,900	31,728
Интернет (60 Mbps ба түүнээс дээш)	45,000	40,262
Фитнесс клуб, 1 насанд хүрэгчдийн сарын төлбөр	220,909	133,448
Теннисний талбай түрээслэх (амралтын өдөр 1 цаг)	52,000	57,938
Кино театрын тасалбар	15,500	13,519
Олон улсын бага сургууль, 1 жил	20,691,667	20,045,883
Цэцэрлэг, бүтэн өдөр, хувийн, сар бүр 1 хүүхэд	516,667	650,180
1 жинсэн өмд (Levis 501 эсвэл ижил төстэй)	133,750	107,378
Сүлжээ дэлгүүрт 1 зуны даашинз (Zara, H&M, ...)	133,750	123,922
1 хос Nike гүйлтийн пүүз (дунд зэрэглэлийн)	263,750	288,079
1 хос эрэгтэй арьсан бизнес гутал	362,857	268,660
Хотын төвд орон сууц худалдан авах м ² -ын үнэ	5,123,077	3,666,011
Сарын дундаж цалин (татварын дараах)	1,573,182	1,062,192
Нэг талын тасалбар (Нийтийн тээвэр)	500	579
Такси (1км Ердийн тариф)	2,000	3,863
Такси 1.6 км (Ердийн тариф)	3,219	773
Бензин (1 галлон)	2,763	2,427
Volkswagen Golf 1.4 90 KW Trendline	103,000,000	119,853,589
Toyota Corolla Sedan 1.6л 97kW Comfort	63,333,333	100,328,874
Өндөг (ердийн) (12 ш)	6,472	5,536
Дарс (дунд үнэтэй), 750 мл шил	30,000	19,313
Нэг хайрцаг тамхи	6,000	4,538
Цагаан будаа, (500гр)	2,447	4,931
Сонгино, 1 кг	1,514	1,597
Алим (500гр)	10,971	2,978
Гадил (500гр)	4,274	5,726
Жүрж (500гр)	5,322	6,470



ТАШКЕНТ	АСТАНА	БЭЭЖИН	ТОКИО	СӨҮЛ
21,209	29,764	16,670	22,899	26,502
100,050	133,937	95,258	130,525	161,705
13,800	19,347	19,052	17,174	21,202
3,623	4,465	4,763	8,015	13,251
5,977	7,999	12,948	8,360	13,737
2,128	3,078	1,735	3,279	5,307
2,284,495	2,669,249	3,163,481	2,256,452	3,015,159
1,397,000	1,855,281	1,979,246	1,429,130	1,944,396
3,923,886	4,854,137	8,047,643	5,272,650	9,308,982
2,438,701	3,357,736	4,160,009	2,584,885	5,914,219
142,564	6,367,927	187,620	407,972	636,318
15,866	28,318	36,926	62,367	171,361
47,303	42,182	48,204	104,665	83,963
145,288	167,008	174,340	135,880	203,962
36,459	58,288	103,701	31,402	59,378
15,544	18,602	23,814	43,508	39,753
26,944,220	36,691,178	94,500,085	45,776,738	9,965,787
827,970	890,591	3,083,553	808,917	1,355,209
196,233	258,308	212,136	88,885	217,087
200,746	147,402	118,811	64,876	164,010
367,945	407,875	292,984	127,919	281,247
414,282	413,505	389,273	180,112	442,539
4,693,319	6,368,573	56,359,390	17,497,738	74,820,071
1,440,461	2,087,906	6,218,282	8,178,915	11,201,243
434	744	2,380	3,435	3,644
2,243	4,465	6,188	11,450	12,721
990	2,232	1,238	15,478	4,265
3,175	1,636	4,125	13,594	4,919.65
51,750,000	74,409,658	76,165,245	45,809,630	99,995,420
73,661,431	99,463,079	73,449,695	36,531,423	89,564,526
6,419	5,905	6,179	6,351	14,127
17,250	26,043	36,893	22,899	58,305
6,900	5,692	12,853	11,450	1,926
5,666	5,070	4,091	3,406	5,777
1,526	1,816	3,647	3,406	5,014
4,525	4,025	6,413	5,708	10,635
6,271	6,795	6,413	3,085	5,973
8,542	7,894	7,004	5,213	9,720

Үнийн дүн бага

Үнийн дүн дундаж

Үнийн дүн их





Б.ГАНТҮЛХҮҮР: Аз жаргалтай, баяр баясалтай ажлын орчныг мэдрүүлэх үүднээс ногоон барилгын ажлыг эхлүүлсэн

Ярилцсан **Э.МИШЭЭЛ**

Хүн амьдралынхаа багагүй цаг хугацааг ажил дээр өнгөрүүлдэг. Тэр утгаараа ямар ч байгууллага ажлын бүтээмжийг сайжруулах, ажиллагсдадаа таатай орчин, нөхцөл бүрдүүлэх боломжийг эрэлхийлдэг. Орчин үеийн чиг хандлага нь энэхүү гарцыг тогтвортой хөгжлийн хүрээнд хайх болсон билээ. Тэрхүү шийдлийг цөөнгүй улс орнуудад хэрэгжүүлж байна.

Харин манай улсын хувьд тогтвортой хөгжлийн шийдлийн нэг болох ногоон барилгыг анхлан хэрэгжүүлж буй байгууллага бол MMS компани юм. MMS компанийн Гүйцэтгэх захирал Б.Гантүлхүүртэй Ногоон барилга гэж юу болох, Ногоон барилгын LEED сертификат, түүнийг хэрхэн нэвтрүүлсэн, ямар ач холбогдолтой зэрэг сэдвээр ярилцлаа.

MMS ХХК нь хөдөө аж ахуй, уул уурхай, барилга, эрчим хүчний салбарт дэвшилтэт технологийн бүтээгдэхүүн, инженер, техникийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Монгол Улсад төвтэй төрөлжсөн ханган нийлүүлэгч юм байна. Танай компани ногоон чиглэлд үйл ажиллагаагаа хөгжүүлэх болсон учир шалтгаанаас ярилцлагаа эхэлье?

MMS, MMS Engineering гэсэн хоёр компани байдаг. MMS нь уул уурхай, барилга, эрчим хүчний салбарт шаардлагатай Allen-Bradley, Schneider зэрэг дэлхийд танигдсан брэнд

бүтээгдэхүүнийг ханган нийлүүлдэг. Харин эдгээр бүтээгдэхүүний угсралт, тохируулга, инженерийн ажлыг MMS Engineering гүйцэтгэдэг. Ийм компани ногоон чиглэлд үйл ажиллагаа явуулах болсон нь анх үзүүлэнгийн танхим, засвар үйлчилгээ, агуулах бидэнд хэрэгтэй гэсэн үүднээс ярьж байсан юм.

Тэгээд яагаад зүгээр нэг оффис байх хэрэгтэй гэж, яагаад Монголдоо өндөр стандарт нэвтрүүлж үлгэр дуурайлал болж болохгүй вэ гэдэг үүднээс ногоон барилгын судалгаа хийж эхэлсэн. Олон улсад ногоон барилга, ухаалаг барилга,

байгальд ээлтэй тогтвортой хөгжлийн ийм төрлийн барилга трэнд болж байна. Түүн рүү эрчим хүч, барилгын салбарын чиг хандлага явж байгааг ойлгосон. Харин манай улсын хувьд аль ч салбарт нэвтрээгүй байна. Ингээд Монголдоо хэрэгжүүлж гэж зориглон энэ төслийг эхлүүлсэн.

LEED ямар хүндрэлийг шийдвэрлэхээр зорьсон бэ?

LEED төслөөр дамжуулж MMS компанийн ажилчдад тав тухтай орчныг бүрдүүлэх, хөгжүүлэх, ажилчдын эрүүл мэндийг анхаарахын үүднээс энэхүү төслийг хэрэгжүүлж байна. Аз жаргалтай, баяр баясалтай ажлын орчныг мэдрүүлэх, тийм байгаасай гэсэн үүднээс хандсан. LEED нь тогтвортой хөгжлийг хангасан, сүүлийн үеийн бүрэн ухаалаг систем бүхий ногоон барилгын төсөл. Ногоон барилгыг судлах явцад олон улсад ийм төрлийн хэд хэдэн сертификат байдгаас нэр хүндтэй гурвыг сонгон судалсан. Үүнээс АНУ-ын LEED буюу Эрчим хүч, байгаль орчны дизайны манлайлал хамгийн нэр хүндтэй нь байсан. Бас Английн BREEAM сертификат байдаг юм билээ. Европын орнууд ихэвчлэн ийм сертификаттай байдаг. Мөн Австралид Green Star гэж байдаг.

Ногоон барилгынхаа талаар товч танилцуулахгүй юу?

Манай барилга хоёр үзүүлэнгийн танхимтай. Хоёр болон гурав дахь давхарт оффис байрладаг. Барилга А, В, С гэсэн гурван блоктор. А блок оффис болон үзүүлэнгийн танхим, В блок засвар үйлчилгээ, С блок агуулах, эдгээрийг холбосон дундаа цэцэрлэгт хүрээлэнтэй. Цэцэрлэгт хүрээлэн гурван блокийг холбохоос гадна блок бүр цэцэрлэгт хүрээлэнг харах таатай нөхцөлийг хангах үүднээс шилэн байдлаар хийсэн. Ер нь бид анхнаасаа барилгын зураг төсөл дээрээ шилэн байх, дээвэр дээрээ нарны хавтантай байх, хойноо борооны ус цуглуулах савтай байх гэсэн захиалгыг архитекторчид өгсөн. Үүнийг монгол архитектор залуу зурсан. Дотоод, гадаадын хүмүүс ирж үзээд, үнэхээр шийдэл сайтай захиалга болжээ гэж сайшаасан.

MMS Green Building нь барилгын зураг төсөл, барилгын үнэлгээний LEED системийн дагуу платиниум гэрчилгээг хэрхэн авсан бэ?

LEED сертификат дотроо шалгарсан, мөнгөн, алтан, платиниум гэсэн дөрвөн ангилалтай. Платиниум шалгуур 80 онооноос дээш байдаг учир бид платиниум ангиллын санал өгөөд алтан сертификат дээр бууна гэж бодож байсан. Гэхдээ платиниумд хүрэхээр зорьсон.

Сертификат авахын тулд LEED байгууллагад хандахад болох юм байна гэтэл зөвлөх үйлчилгээ заавал авах хэрэгтэй болсон. Ингээд Шанхайд төвтэй, дэлхийн 14 оронд ногоон барилгын төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг B enterprise-ийг сонгосон. Зөвлөх үйлчилгээний компанитай барилгын зураг төслийн үеэс хамтарч ажилласан учраас олон оноо цуглуулах боломжийг бүрдүүлсэн. Шалгаруулалт оноо цуглуулах зарчмаар явагддаг. Жишээлбэл, шалгарсан гэдэг үнэлгээг авахын тулд 60 хүртэл, мөнгөн 60-70, алтан 70-80, платиниум 80-аас дээш гэж явдаг. Гадна зогсоол, ногоон байгууламж, ус цуглуулах, нарны эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, агааржуулалт, барилгын материалын ашиглалт гэх зэргээр оноо цуглуулдаг. Манайх 82 оноо авсан.

Ногоон барилгыг яагаад Яармагт байгуулахаар шийдсэн бэ?

Бид ногоон барилга барих санаагаа 5-6 жилийн өмнөөс гаргасан. Хотын бүсчлэлээр авч үзэхэд хот төлөвлөлтөөр Яармагт шинэ барилга байгууламж, авто зам, дэд бүтэц хийгдэхээр болж байгааг бид мэдсэн. Нөгөө талаас бизнесийнхээ онцлогийг харвал, гадаадынхантай хамтарч ажилладаг учраас нисэх онгоцны буудал дагуу газрыг сонгосон. Маркетингаа бодсон ч нисэхээс буусан хүмүүс оффисыг харах боломжтой.

Бид анхнаасаа барилгын зураг төсөл дээрээ шилэн байх, дээвэр дээрээ нарны хавтантай байх, хойноо борооны ус цуглуулах савтай байх гэсэн захиалгыг архитекторчид өгсөн.

Эрчим хүчний хэрэглээгээ 100% сэргээгдэх эрчим хүч буюу нарны хавтангаар шийдвэрлэсэн нь анхаарал татаж байна?

Усаар хангахаар бол усны нөөц байх шаардлагатай. Харин салхины эрчим хүч төв суурин газарт барих нь аюулгүй талаасаа зохимжгүй. Иймээс нарны эрчим хүчийг сонгосон. Мөн нарны хавтангаас авсан эрчим хүчийг нөөцөлж, оргил ачааллын үед дарамт учруулдаггүй. Ер нь нарны системээс гадна эрчим хүчээ хадгалах батарейн систем, удирдлагын ухаалаг систем хоорондоо хоршиж ажилладаг.

Ногоон барилгад шууд утгаараа ногоон байгууламж шаардлагатай гэж ойлгож байна?

LEED төсөл 36% нь ногоон байгууламжтай байх шаардлага тавьдаг. Ногоон сертификатад зүлэг, өвс орохгүйгээр хэдэн хувь нь модлог, бутлаг ургамал байх, тэр дотроо ус бага хэрэглэдэг байх ёстой вэ гэж заасан байдаг. Манай барилгын онцлог нь хавар, зун, намартаа борооны ус цуглуулж усалгаа хийдэг нь давуу тал болсон.

Гадаад улс орнууд LEED-ийг хэрхэн нэвтрүүлж байна вэ?

LEED-ийг 168 орон авсан. Хятадад ийм сертификатуудыг эрчимтэй авч байна. Цаашлаад Өмнөд Солонгос, Тайвань, Энэтхэг, Арабын Нэгдсэн Эмират зэрэг Азийн улс орнуудад нэвтэрсэн. Америкт гэхэд 2035 онд LEED сертификатгүй барилгыг хуучны барилга гэж үздэг болно. Стандартыг өндөр болгоно гэж байгаа юм билээ.

Ярилцсанд баярлалаа.





Хүний амьсгалсан агаараар амьсгалах нь ажлын бүтээмжийг бууруулдаг

Яармагийн тойргийн урд, Чингис хаан олон улсын нисэх буудал руу явах замд барилгынхаа хэмжээнээс хамаагүй том талбай бүхий ногоон байгууламжтай, хийц дизайны хувьд анхаарал татахуйц шилэн барилга харагддаг. Цагаан өнгийн тэрхүү барилга бол олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Ногоон барилга юм. Энэхүү Ногоон барилгыг MMS компани монгол

архитекторч, инженер, барилгачдын хамтаар босгожээ.

Ногоон барилгын хувьд усанд хэмнэлттэй, усыг дахин ашигладаг, дотоод эрүүл ахуйн чанар буюу агаарын урсгал сайн, байгалийн гэрлийн ашиглалт сайн, сэргээгдэх эрчим хүчийг ашигладаг гэсэн үндсэн ойлголтууд байдаг. Нөгөө талаар Ногоон барилга гэдгийг шууд утгаар нь ногоон

байгууламжтай барилга гэж ойлгож болно. MMS компанийн энэхүү төслийн нийт талбайн ¼ нь ногоон байгууламжаас бүрджээ. LEED +C буюу зураг төслөөс нь эхлэн ногоон барилгын стандартад тааруулан барьжээ. Ийм стандарттай барилга олон улсад цөөхөн байдаг байна.

Ногоон барилга өөр өөр уур амьсгалыг мэдрүүлэх гурван цэцэрлэгт хүрээлэнтэй. Үүнээс хамгийн сонирхолтой нь 360 хэмд харагдац бүхий Өвлийн цэцэрлэгт хүрээлэн юм. Барилгын голд байх цэцэрлэгт хүрээлэн нь 9 төрлийн мод, буттай. Эдгээр мод, бутыг агрономичоос зөвлөгөө авч суулгажээ. Учир нь зарим ургамлууд нэгийгээ ургахыг дэмждэггүй тал бий. Түүнчлэн ус бага шаарддаг мод, бут суулгахыг LEED-ээс зөвлөдөг байна. Өөр нэг цэцэрлэгт хүрээлэн нь барилгын баруун талд байрлана. Тус цэцэрлэгт хүрээлэнг япон маягийн загвартай хийжээ. Энд чацаргана, долоогоно, нохойн хошуу, мойл, зэрлэг сарнай, хөх гацуур, канад гацуур зэрэг 10-аад төрлийн мод, бутнууд ургаж байна. Үлдсэн цэцэрлэгт хүрээлэнг авто машины зам дагуу, барилгын үүдэн хэсгийн урд тохижуулжээ.

Ногоон байгууламжийг услахын тулд 50 тоннын усны савыг Өвлийн цэцэрлэгт хүрээлэнгийн доор суурилуулсан байна.

Ногоон байгууламжийг услахын тулд 50 тоннын усны савыг Өвлийн цэцэрлэгт хүрээлэнгийн доор суурилуулсан байна. Ингэснээр төвлөрсөн усан хангамжийн сүлжээнээс жилд 400 тонн ус хэмнэх юм. Нөөцлөх усны хувьд барилгын дээврийн хоолой болон ойр орчмын талбайн усыг хоолой ашиглан хуримтлуулах юм байна.

Ногоон барилгад байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл



мэндэд сөрөг нөлөөгүй гэсэн хоёр үндсэн шаардлага тавьдаг. Энгийн мэт боловч энэхүү стандартыг бий болгохоор 1993 оноос АНУ-ын Байгалийн нөөцийг хамгаалах зөвлөлийн эрдэмтэн Роберт Ватсоны удирдлага дор Ногоон барилгын зөвлөлийн дэмжлэгтэйгээр ашгийн бус байгууллагууд, Засгийн газрын агентлагууд, архитекторууд, инженерүүд, барилгачид, үйлдвэрлэгчид, холбоод, холбогдох бусад салбарын оролцоотойгоор 20 жилийн турш сайжруулсаар иржээ. Тэр цагаас хойш өнөөдөр дэлхийн 160 гаруй оронд, 100 мянга гаруй LEED гэрчилгээтэй барилга бий болжээ. LEED-ийг оффис, музей, сургууль, цэнгэлдэх хүрээлэн, нисэх буудал гээд бүх төрлийн барилгад авах боломжтой.

MMS оффисын ногоон барилга сэргээгдэх эрчим хүчээр нарны эрчим хүчийг сонгожээ. Яагаад нарны эрчим хүч сонгосныг тодруулж асуухад Худалдаа маркетингийн ахлах менежер Ё.Тэнгэрболд “Монгол орон хуурай уур амьсгалтай болохоор салхи нь сийрэг. Иймээс үр ашигтай байх боломж багатай” гэлээ.

Нарны эрчим хүчээ хоёр давхарт байрлах батареинд хураадаг. Одоогоор хоолны газар, засварын цех ашиглалтад



ороогүй тул батареи дүүрсэн тохиолдолд төвийн шугам руу нийлүүлж байна. Нарны эрчим хүчний хүчин чадлын хувьд 168 кВт цаг. Мөн төвийн эрчим хүчний систем болон батареи үүсгүүрээс цахилгааны хэрэглээг хангадаг тул цахилгааны саатал гарна гэж санаа зоволтгүй ажиллах боломжтой. Нарны хосолмол эрчим хүчний системийг суулгаснаар эрчим хүчний зардлаа одоо байгаа кВт цагийн үнэтэй харьцуулахад 15 жилд нөхнө гэж тооцоолжээ. Тус компани Монголдоо анх удаа дээвэр дээрх нарны эрчим хүчний системийг суурилуулсан байна.

Барилгын агаарыг усан хөргүүрийн агааржуулалтын системээр зохицуулалт хийдэг. Агаарыг хүйтэн усаар чийгшүүлж агаарын урсгалд оруулдаг байна. Ингэснээр ажиллагсдын арьс хуурайших, агааржуулалтаар дамжиж ханиад хүрлээ гэсэн яриа гарахгүй юм.

Ё.Тэнгэрболд “Хүний бухимдал, стресс нь агааржуулалттай холбоотой юм билээ. Хүний амьсгалсан агаараар амьсгалах нь ажлын бүтээмжийг бууруулдаг. Манай барилга 24 цагийн дотор бүрэн агаарын сэлгэлт хийгддэг” гэлээ. Агаарын тохируулга автомат мэдрэгчтэй учраас нэг өрөөнд 10 хүн, нөгөө өрөөнд 5 хүн сууж байвал үүнийг мэдрч, олон хүнтэй өрөөнд илүү агаарын тохируулга хийгдэнэ. Барилгын доторхыг хэдэн үгээр тодорхойлъя гэвэл “цэвэр агаар,

байгалийн гэрэл” гэж болох аж.

Барилгын ажил 2019 онд эхэлсэн бөгөөд ашиглалтад оруулах хугацаа 1.5 жил байсан ч цар тахал гарсантай холбоотойгоор 2022 онд дуусжээ. Барилга төмөр карказан хийцтэй. Барилгын шил нарны хэт ягаан туяанаас бүрэн хамгаалсан дөрвөн давхар шилтэй. Гаднаасаа энгийн мөртлөө үзэмжтэй шийдэл дотор нь ч ажиглагдана. Барилгын халаагуур, сангийн шугам, цахилгааны шугамыг тааз болон шалны хөндий зайд байрлуулжээ. Энэ нь илүү цэгцтэй харагдахаас гадна засвар үйлчилгээ хийхэд хялбар болгодог. Тус барилгыг хэрхэн хийсэн талаар байгууллагуудад танилцуулсны дараа тэд өөрсдийн туршлагадаа үндэслэн Ногоон барилгын ажлыг үнэлцгээдэг аж. Биднийг Ногоон барилгатай танилцах үеэр өөр хөтөчтэй цуг Голомт банкныхан явж байсан юм.

Ногоон барилга хүнд ээлтэй байхын нарийвчилсан жишээ нь принтерийн тусдаа өрөө. Принтерийн хор бага хэмжээгээр хор ялгаруулж байдаг. Иймээс принтер шилэн бүхээг бүхий өрөөтэй. Мөн удаан байлгахгүй гэсэн үүднээс принтерийн өрөөний ханыг улаан өнгөөр буджээ. Барилгад бүхэлдээ ухаалаг систем нэвтэрсэн. Аль ч өрөөнд ороод өрөөний хэм, гэрэл, агааржуулалтыг тохируулах боломжтой. Серверийн өргөтгөл хийж дууссаны дараа гар утаснаасаа ч ийм тохиргоог хийж болох аж.

Бусад байгууллагууд давхар давхартаа цахилгааны төвлөрсөн удирдлагаа хийдэг бол энд нэгдсэн нэг удирдлагын өрөөнөөс зохицуулдаг байна. Хаана цахилгааны ачаалал үүссэн, хаана тасарсныг дижитал аргаар тогтоохоос гадна индикаторуудын тусламжтай олж болдог. Удирдлагын өрөөнд байх үед нарнаас авсан эрчим хүчийг батареи рүү шахаж, заримыг нь төвийн сүлжээ рүү нийлүүлж байгаа нь тохируулгын дэлгэцнээ харагдаж байв. LEED-ийн платиниум үнэлгээг авахад хамгийн өндөр оноог цахилгаан эрчим хүчтэй холбоотой оноонуудаар авчээ.

Ногоон сертификат авсан компани олон улсын байгууллагуудтай харилцахад ногоон барилгатай гэвэл хандлага илүү сайжирдаг байна. Ногоон барилгыг барьж буй MMS компани бизнесийнхээ ирээдүйг ч давхар тооцоолжээ.

Ногоон барилга нь шавхагдаж дуусах нөөцийг зөв зохистой ашиглах, шавхагдашгүй нөөцийг тэгш хуваарилах тухай юм. Тэд барилгын ажлын явцад гарсан 15.3 тонн хогны 70%-ийг ангилж хаясан байна.

Ногоон барилга нь тухайн газрынхаа байгалийн тогтцыг эвдэлгүй баривал илүү оноо цуглуулдаг. Тэр хавийн газар баруунаас зүүн тийшээ бага зэргийн налуу байрлалтай хэдий ч газрыг эвдэлгүйгээр барилгыг угсарсан байна. Барилгын явцыг харахад яг л леги шиг харагдаж байсныг Ё.Тэнгэрболд хэлж байлаа.

Өөрөөр хэлбэл орчин үеийн хүнд төвөг дараа болохгүй байх философийг барилга барих явцад ч хэрэгжүүлж болох аж. Барилгын хоёр хажуу тал, хойд хэсгийг бетоноор цутгасан бол төвийн замтай холбогдож буй хэсэг, зогсоолыг асфальтаар хучжээ. Барилгын зүүн хэсэгт багахан хэмжээний усан сан байгуулахаар бэлтгээд байна. Барилгын хашаа зэрэг жижиг ажлууд л үндсэндээ үлджээ. Энэ бүгдийг чамбайруулсны дараа Ногоон барилгын нээлтийг хийхээр төлөвлөж байна.



Ногоон барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч BEE Incorporation

BEE Incorporations нь барилгын тогтвортой хөгжлийн шийдэлд мэргэшсэн материалын мэргэжилтэн, инженерингийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллага юм.

BEE корпораци нь 2009 онд Шанхай хотод "Bisagni Environmental Enterprise" нэртэйгээр байгуулагдан цар хүрээгээ тэлсээр өдгөө 12 улсад үйл ажиллагаагаа явуулж, дэлхийн өнцөг булан бүрийг хамарсан 40 орчим улсад 800 гаруй төслийг хэрэгжүүлээд байна.

BEE корпораци Монгол Улсад 2019 онд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн, Монголын хамгийн анхны бөгөөд цорын ганц Ногоон барилгын цогц зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллага юм.

НОГООН БАРИЛГЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Ногоон барилгын зөвлөх үйлчилгээ нь барилга, байгууламж, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн инженерийн зөвлөх үйлчилгээ, гэрчилгээжүүлэлт, ногоон материалын шийдэл зэргийг багтаасан цогц үйлчилгээ юм.

1. Тогтвортой инженерчлэлийн зөвлөгөө
2. Ухаалаг барилгын шийдлүүд
3. Барилгын гүйцэтгэлийн үнэлгээ
4. Тогтвортой материалын зөвлөгөө

Ногоон барилгын гэрчилгээжүүлэлттэй болсноор байгаль орчин, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг сайжруулан, таны төслийг өндөр чанар бүхий хөрөнгө оруулалт болгон хувиргадаг.

Ногоон барилгын гэрчилгээжүүлэлтийг ТӨСЛИЙН АЛЪ Ч ҮЕ ШАТАНД авах бүрэн боломжтойгоос гадна бүрэн баригдаж ашиглалтад орсон барилгын агаарын чанар, эрчим хүчний ашиглалт, инновац шинэчлэл зэргийг дахин төлөвлөж, гүйцэтгэснээр гэрчилгээжүүлэх боломжтой.

ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ:



ГҮЙЦЭТГЭСЭН ТӨСЛҮҮД:



PRADA
LEED v4 ID+C, LEED Gold certification level



MMS Green building
LEED v4 BD+C, LEED Platinum certification level



Cathay Taipei
Tower
LEED CS v2009,
LEED Gold
certification level


НОГООН БАРИЛГЫН ТАНИЛЦУУЛГА СУРГАЛТ ҮНЭГҮЙ

Дэлгэрэнгүй мэдээлэл
авах:

Утас:
99156981, 99005789

Имэйл:
maya.i@bee-inc.com
nomindari.j@bee-inc.com





Ногоон байгууламжийн хүртээмж ба

ХАЛААСНЫ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

Улаанбаатар хотод ногоон байгууламжийн хэрэгцээ өндөр байдаг ч томоохон бүтээн байгуулалт хийх боломж хомс билээ. Манай нийслэлийн нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 5.1 м.Кв. Энэ нь ДЭМБ-аас зөвлөсөн хэмжээнээс хоёр дахин бага.

Харин нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд одоогоос гурван жилийн дараа гэхэд энэ тоог 8 м.Кв болгож нэмэгдүүлэх зорилт тавин хэд хэдэн томоохон төслийг хэрэгжүүлж байна. Уг зорилтод хүрэхэд бүтээн байгуулалтаас гадна алслагдсан дүүрэг хороодын ногоон байгууламжийг нэмэгдүүлж хүртээмжийг шийдэх нь зүйтэй юм.

Уг асуудлын боломжит шийдлийн нэг нь халаасны цэцэрлэгт хүрээлэн. "Pocket Park" буюу халаасны цэцэрлэгт хүрээлэн нь хотын ашиглагддаггүй нийтийн орон зайг хүн төвтэй дизайны аргачлалаар тохижуулж, жижиг ногоон төгөл бий болгодог онцлогтой. Халаасны

цэцэрлэгийн түүх нь дэлхийн II дайны дараах сэргээн босголтоос үүдэлтэй бөгөөд 1950-аад оноос дэлхийн томоохон хотууд хэрэгжүүлж эхэлжээ.

Тэгвэл Улаанбаатар хотоор алхахад хаа сайгүй тааралддаг эвдэрхий тоглоомын талбай, овоолсон шороо ч ногоон байгууламж болох боломжтой юм.

Халаасны цэцэрлэгийг илүү олон болгосноор:

- Хотын оршин суугчдын бие болон сэтгэцийн эрүүл мэндэд сайнаар нөлөөлөх
- Агаарын хэт халуун хэмийг багасгаж, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх
- Хотод орхигдсон талбайн тоог бууруулж, ашиглалтын хэлбэрийг нэмэгдүүлэх
- Иргэдийн цуглах орон зай нэмэгдэж, хотын сэтгэлгээг суулгах гэх мэт эерэг үр дагавартай.

"Гончигсумлаа" сан, Глобал Шейперс Улаанбаатар



IG: @toshigmoshig

нийгэмлэг болон H.O.W Architects-ийн хамтран хэрэгжүүлж буй "Улаанбаатар Төгөл" нь Улаанбаатар хотод тулгамдаад буй ногоон байгууламжийн хүртээмжийг халаасны цэцэрлэгт хүрээлэнгээр нэмэгдүүлэхийг зорьж буй төсөл юм. Уг төсөл нь гэр хорооллын бүсийн нийтийн эзэмшлийн зай талбайг иргэдийн цуглах ногоон байгууламж болгон сайжруулах юм.

Хотын ногоон байгууламж нь эрүүл, хүртээмжтэй, тогтвортой хотыг цогцлоох, иргэдийн амьдралын чанар, эрүүл мэндийг сайжруулахад чухал үүрэгтэй. Ногоон байгууламж хангалттай хэмжээнд хүрвэл хотын байгаль орчин болон бидний амьдралд дараах эерэг өөрчлөлтийг бий болгоно.

Уур амьсгалын өөрчлөлтэй тэмцэхэд туслах хүчин зүйлсийн нэг гарцаагүй мөн.

- Мод нь фотосинтезийн замаар агаар мандлаас нүүрстөрөгчийн давхар ислийг (CO₂) шингээдэг бөгөөд нас бие гүйцсэн мод жилд 150 кг CO₂-ийг өөртөө шингээх чадалтай. CO₂ нь уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн нөлөө үзүүлдэг хийнүүдийн нэг.

Модны дэргэд цагийг өнгөрөөх нь бие махбод болон сэтгэл зүйн эрүүл мэндэд эергээр нөлөөлдөг.

- Тухайлбал, модноос ялгарах фитонцид хэмээх

эфирийн тос нь дархлааг сайжруулж, энергийн түвшинг нэмэгдүүлж, стресс тайлдаг онцлогтой.

Эрчим хүчний хэрэглээний хэмнэлтэд үр нөлөө үзүүлнэ.

- Барилга байгууламжийн эргэн тойронд зөв байршилд тарьсан мод нь агааржуулагчийн хэрэгцээг 30 хувь хүртэл бууруулдаг бөгөөд өвлийн улиралд салхины хамгаалалт болж, хүйтэн салхийг хааж, барилгын дулаан алдагдлыг багасгадаг.


Тогтвортой эрүүл хотын хүрээлэн буй орчныг бүтээхэд иргэн бүрийн оролцоо чухал. "Улаанбаатар Төгөл" төсөл нь ногоон байгууламжийг харах иргэдийн өнцгийг өөрчлөн хүртээмжийг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

Нийтлэлийг:

"Улаанбаатар төгөл" төсөл



*Намайг
гуйгуул*





Нийтлэлийг
Б.ЗОЛЗАЯА



Тако Винтеж дэлгүүр

Хотын залуус ба ВИНТЭЖ СОЁЛ

Ээж болон эгчийнхээ “хуучин хувцас”-ыг өмсөх болоход үе тасарчихсан насны зөрүүтэй бид гурвын хувьд хүндхэн зөрчилтэй тулгардаг байв. Өмсүүлэх гээд байгаа хувцасных нь загвар огт таалагдахгүй. Дээрээс нь хуучин загварын хувцас өмсчихөж гэж үе тэнгийн хүүхдүүд шоолохоос ичээд тийм ч таатай хүлээж авдаггүй байж. Цаг хугацааны эрхээр ухаан сууж, бас амьдрал үзэж, оймсоо нөхөөд өмсдөг болохын цагт ээж, эгч хоёрыгоо ойлгож эхэлсэн юмдаг. Харин одоо бол ээж, эгчийнхээ хуучин хувцсыг өмсөхдөө хэнээс ч ичихгүй, юунаас ч санаа зовохгүйгээр “алив намайг хар даа, харцгаа” гээд гайхуулдаг үе иржээ.

Мэдээлэл түгэх хурдаас шалтгаалан бид дэлхий дахинаа ямар хандлага ноёлж, юу трэнд болж, ямар танигдаагүй, чимээгүй соёл ил гарч ирж, ярианы сэдэв болж буйг цаг алдалгүй авч чаддаг болжээ. Тэгвэл тэдний дундаас онцлох нэг соёл бол хаа сайгүй дэлгэрэн түгэж буй “хуучин хувцасны соёл” юм.

Хуучин хувцас гэдгийг өнөөдөр хэрэглээнийх нь хувьд ерөнхийдөө Винтеж хуучин хувцас болон энгийн хуучин хувцас гэж хоёр ялгаж байна.

Винтеж хуучин хувцас гэдэг нь дор хаяж 20 жилээс

дээш цаг хугацааг элээсэн үнэ цэнтэй, түүх өгүүлэх ганган чамин, ховор хувцсыг хэлэх аж. Тэр ч утгаараа өндөр үнэтэй худалдаалагддаг. Харин энгийн хуучин хувцас гэдэг нь хүмүүсийн саяхан эсвэл хэдхэн жилийн өмнө аваад хэрэглэхээ больсон хувцаснууд юм. Эдгээр хувцсыг нэг дор бөөгнүүлээд, өөр хэн нэгэнд худалдаалан борлуулах зорилготой дэлгүүрийг трифт дэлгүүр гэдэг. Трифт дэлгүүрээс худалдан авалт хийхийг залуучууд “трифтлэх” гэж ярьцгаах нь бий. Трифт гэдэг үг нь өөрөө ашигтай тохиролцоо, мөнгө хэмнэлт гэдэг утга санааг илэрхийлдэг.

Иймэрхүү байдлаар өнгөцхөн ялгаж болох хэдий ч арай илүү гүн рүү нь орох гээд үзье. Стил, имиж талаас нь тайлбарлавал Винтэж дэлгүүр бол үйлчлүүлэгч болон хэрэглэгчдийнхээ стилийг тодорхойлогч, бүтээгч нь гэж харж болно. Учир нь дэлгүүрийн эзэд Винтэж хувцсыг судлах, эрж хайх, олж авахад ихээхэн хөдөлмөр, цаг хугацаа зарцуулдаг.

Ингэж байж өнөө цагт хэний ч өмсөж байгаагүй, үзээгүй, мэдээгүй загвар мода бүхий материал болон өнгөний зохицол, хээ хуартай, этгээд содон хийц шийдэлтэй хувцас, нүдний шил, цүнх зэрэг ховрын бараануудыг шилж цуглуулан, санал болгодог юм. Харин хэрэглэгч нь тэдгээр цор ганц сонголтуудаас сонголтоо хийж, өөрийгөө өөрөөр бүтээнэ гэсэн үг.

Харин трифт дэлгүүрт орвол замбараагүй олон сонголтоос сонголт хийж таарна. Тэр дундаас шинээр өөрийгөө бүтээж болно. Эсвэл өөрийнхөө стил хэв маягт нийцсэн хувцас, гуталнуудаас ч сонголт хийж болно. Энгийн загвартай нь ч байна, содон сонин загвар, маягтай нь ч байна. Өөрөөр хэлбэл трифт дэлгүүрт өөрөө өөрийнхөө сонголтоор өөрийгөө бүтээнэ гэсэн үг. Харин ихэнх хувцас нь нас богино, эдэлгээ хурдан байх магадлалтай.

Мөн трифт дэлгүүрийг “эрдэнэсийн эрэлд” хэмээн хочилж болох юм. Учир нь нэг бүрчлэн сайн ухаж чадвал Винтэж хувцсыг ч олох боломжтой.

Үнээр нь харьцуулбал Винтэж дэлгүүрийн бүх зүйл үнэтэй. Бүр даварчихсан үнэтэй нь ч бий. Энэ нь ил харагдах сул тал мэт боловч эсрэгээрээ хүмүүсийг амьдралд хэрэгтэй дадал, сэтгэлгээнд суралцуулдаг далд нэгэн хүч түүнд бий. Энэ нь чанар муутай зүйлийг олон дахин худалдаж авахын оронд чанар чансаатай, өөрт таалагдсан ховор тэр нэг Винтэж хувцсыг өндөр үнээр нэг л удаа авах сонголтыг хийлгэдэг гэсэн үг.

Хуучин хувцасны төлөө их мөнгө зарцуулна гэдэг хайран. Гэхдээ яаж хөдөлмөрлөж олсон мөнгөөрөө юу авах гэж байгаа билээ, ямар хувцастай яаж зохицуулж өмсөх вэ гэх зэргээр бодлого бодож, хариугаа олсны дараа худалдан авалт хийдэг тул санхүүгийн сахилга батыг шаарддаг.

Бичсэн сэдэвтэйгээ уялдуулаад Улаанбаатарт байдаг трифт дэлгүүрүүдээс санал болгоё.

1. Сонин содон стил бүтээе гэвэл Хүүхдийн зууд байрлах “Тойрог” трифт дэлгүүрийг зориорой. Ажиллаж байгаа хүмүүс, орчин зэрэг нь таныг яалт ч үгүй сонирхолтой шинэлэг зүйл рүү уруу татна. “Тойрог” нь маш олон салбар дэлгүүртэй, трифт соёл болон энэ чиглэлийн хандлагыг Улаанбаатарт таниулж байгаа дэлгүүр гэж хэлж болно.

2. 988 трифт дэлгүүр нь кофе шоптойн зэрэгцээ яг залуучуудын дунд трэнд болоод буй стилийн хувцаснуудыг оруулж ирдэг. Тиймээс Жен 3 нарын маань очих дуртай газар нь.

3. Тако Винтэж хувцасны дэлгүүр” нь Японы Винтэж дэлгүүрийн соёлыг 3 жилийн хугацаанд онлайн дэлгүүрээрээ дамжуулан түгээж ирсэн бөгөөд энэ жилээс албан ёсоор дэлгүүрээ нээсэн. Бүх хувцас нь Японоос орж ирдэг гэдгээрээ онцлог ба өөрсдийн гэсэн хэрэглэгчидтэй дэлгүүр юм.

Харин трифт дэлгүүр санхүүд мэдэгдэхүйц хэмнэлттэй тул Жен 3 болон Миллениал залуусын дунд трэнд болж буй амьдралын хэв маяг юм. Өөрт хэрэгтэй зүйлээ боломжийн үнээр авна гэдэг ухаалаг шийдэл мөнөөс мөн. Харин зарим хүмүүст “хямдхан юм чинь нэг ээлжинд авчихад илүүдэхгүй” гэх сэтгэлгээ суулгахыг үгүйсгэхгүй. Эхэндээ ашигтай мэт санагдах ч харин дараа нь нэг их хичээл зүтгэл гаргахгүйгээр олж чадахуйц үнээр авсан болохоор чанаргүй их зүйлээс хурдан уйдаж, авсандаа харамсаж магадгүй л юм.

Трифт дэлгүүрийг байгаль дэлхийд ээлтэй гэдэг өнцгөөр нь түлхүү тайлбарладаг. Хэрэглэхээ больсон нэгнээс хэрэгтэй нэгэнд нь дамжин өртөөлж байгаа тул хаягдал гаргалгүйгээр дахин эргэлдүүлэх үйл явцыг бий болгодог



“Тако винтэж хувцасны дэлгүүр”



учраас тэр юм. Гэвч эцсийн дүндээ нэгэнт эдэлгээ богиноссоор байгаа хувцас шинэ эзэндээ очлоо ч дараа нь хаягдаж л таарна. Гол нь хаях цагаа л хойшлуулсан төдий хэрэг юм.

Харин Винтэж дэлгүүрийн хувьд хуучрах, гандах тусмаа үнэ цэн нь өсөж, үр хүүхдэдээ өгч өв залгамжлуулах түвшинд очдог нь жинхэнэ утгаараа састэйнэйбли гэдэг үгийг тодорхойлдог нэг жишээ юм. Энэ бол хамгийн том өгөөж нь. Мөн сайн бодож, зардал гарган байж авсан тул хувцсаа хайр гамтай эдэлж хэрэглэх хандлагыг эзэндээ суулгадаг. Угаахдаа хүртэл сэтгэл гаргадаг болно. Цэвэрхэн өмсөхийг зорих тул угаах давтамж цөөрснөөр ус тог хэмнэж чадна. Энэ бүхэн амьдралын хичээл зааж буй соёл юм. Бас дээрээс нь гудамжинд өөртэй чинь ав адил хувцастай хүн

хажуугаар чинь зөрөхгүй болохоор сэтгэл ханамж 100 хувь. Угаас үүнийг ойлгож мэддэг хүн л Винтэж хувцасны худалдан авалт хийх тул уйдсан ч, өмсөхөө больсон ч өөр хэн нэгэнд уламжлуулах эсвэл өөртөө хадгалж авч үлдэнэ гэдгээ ч тооцоолсон байдаг.

Ер нь Винтэж ч байна уу, энгийн хуучин нь ч байна уу, ялгаагүй хоёулаа л хаяж болох зүйл. Энэ тохиолдолд техник технологийн ачаар хаягдал хувцсаар дахин материал бүтээх, эсвэл цаас гаргаж авах зэрэг олон шийдлүүд боловсорч гарсаар байна. Бүр өмсөхгүй ч гэсэн хаяна гэхээр хайран санагдаад байвал "upcycling" буюу хуучирч муудсан эд зүйлээ хаяхын оронд сайжруулж хөгжүүлээд, өөр шинэ төрлийн бүтээгдэхүүн болгож, дахин амь оруулах аргыг ч мөн ашиглаж болно.



IG: @timetravelchaos




IG: @tselmeen



IG: @nomiingerel




IG: @khuslen_hearty



Estonia, Finland
Feb 2024

MFF
**MONGOLIAN
FILM FESTIVAL**

Хотын залуус юу сонсдог вэ?



Японд 1970-1980 оны үед “City Pop” нь төдийлөн олон хүнд хүрч чадаагүй ч YouTube-ийн алгоритмын алдаанаас үүдэж хөгжмийн ертөнцөд эрчийг авах болсон. Тэгвэл “City Pop”-ийн гол төлөөлөл болох дуучдын талаар онцолж байна.



Тацүро Яамашита: Тацүро Яамашитагийн алдарт хүрэх замнал 1973 онд ирээдүйн City Pop-ийн одууд болох Таэко Онүки болон Күнио Мүрамацүтай хамтран ‘Sugar Babe’ хамтлаг нь ‘Songs’ хэмээх ганцхан цомог гаргасан ч, энэ цомог мөн үүнийг бүтээсэн дуучид, хөгжимчид, продюссерууд, J-Pop-ийн түүхэнд тодоор тэмдэглэгдэх учиртай байжээ.

1976 онд Тацүро Яамашита хамтлагаасаа гарч RCA Records-ийн уран бүтээлч болжээ.

1976 оноос эхлэн жил бүр цомог гаргаж байсан ч 1980 оны Ride on Time цомог түүнийг Япон даяар алдартай дуучин болгожээ.

Марияа Такэүчи: Марияа Такэүчи 1978 онд оюутан байх үедээ ‘Modotte-Oide’ ‘Watashi no Jikan’ дуугаараа анх уран бүтээлийн гараагаа эхлүүлжээ. Үүний дараа т5 цомог гаргаж ‘September’ ‘Sweetest Music’ зэрэг дуугаараа багагүй алдарт хүрчээ. Сонирхуулахад, 1980 оны Miss M цомогт багтсан ‘Heart to heart’ дуунд The Carpenters хамтлагийн дуучин Karen шинээр үг бичиж ‘Now’ гэдэг дуу болгон гаргасан байна. Now хэмээх энэ дуу нь The Carpenters хамтлагийн бичүүлсэн хамгийн сүүлийн дуу юм.

1982 онд Марияа Такэүчи Японы City Pop-ийн хаан Тацүро Яамашитатай гэрлэж охинтой болжээ. Энэ үед түүний карьер түр завсарласан байна. Гэвч 1984 онд Variete цомгоо гаргаж карьераа дахин эхлүүлсэн юм. Түүний зургаа дахь бие даасан цомог болох Variety нь Plastic Love дууг агуулсан гэдгээрээ алдартай. Хэдийгээр ‘Plastic Love’ тухайн үедээ төдийлөн амжилттай байгаагүй ч цомог дээрх олон дуу амжилт олж Марияа Такэүчийг City Pop урсгалын алдартай дуучин болгожээ. Тэрээр 1984 оноос хойш долоон студио альбум бичүүлж, цомог бүр Японы Oricon Music Chart-д нэгт жагсаж байсан нь түүний нэр хүндийг гэрчилнэ.

Марияа Такэүчигийн уран бүтээл 80-аад онд ихээхэн амжилттай байсан түүний дуунууд ялангуяа ‘Plastic Love’ varogwave, future funk зэрэг шинэ урсгалуудтай холбогдож 2010 онд дахин олон нийтийн анхаарлын төвд оржээ.



Fat Cat Jazz Club: нь Улаанбаатар хотын төвд байрлах хамгийн отгон бас завгүй, цор ганц жазз клуб юм. Google reviews, Tripadvisor, Top-rated. online хайлтын системүүдээс “nightlife” ангилалд хамгийн өндөр үнэлгээтэй буюу илэрцээрээ 1-рт бичигддэг Фат Кат Жазз клуб нь 43 залуусын дэмжлэгтэйгээр “crowdfund” буюу олон нийтийн оролцоотойгоор анх




Illustration art:
IG: @dbwuzhere



© Bodikhuu:

Бодьхүү нь Улаанбаатар хотоос гаралтай хөгжмийн продюссер, хип хоп урлагт дуртай нэгэн. Түүний гэртээ хийсэн хөгжмийн аялгуу дэлхийн хотуудыг тойрдог гэж хэлхэд болно. Учир нь түүний цомгууд болох Welcome to Ulaanbaatar, Рио, Токио, Москва гээд цомгууд нь тухайн улсын дуу хөгжмийн бүтээлүүдээс дээж авч дээр нь өөрийн өнгө төрхийг шингээсэн бүтээлүүд байдаг.

Бодьхүүг сонсохыг хүсвэл хөгжмийг бүх стрийминг үйлчилгээнүүдээс түүний сувгийг сонгоорой. Дэлхийн өнцөг булан бүрийн хотуудын өнгө аяс бүхий хөгжим сонсох үнэхээр сайхан.





Б.Мэнд-Амар



Э.Эрдэнэ

Гэрэл зургийг О.Төгсбилэг

Тал нутгийн хотыг нээхүй

Улаанбаатар хотын иргэдэд амьдарч буй хоттойгоо ахин танилцаж, хотын амьдралыг шинээр харах боломжийг олгох зорилготой “Урбан Волкс” төслийн талаар төслийг хэрэгжүүлэгч Б.Мэнд-Амар, Э.Эрдэнэ нартай ярилцлаа.

“Урбан Волкс” төслийн талаар танилцуулахгүй юу?

Б.Мэнд-Амар: Энэхүү төслийг Зүүн Азийн бүсийг хариуцсан БНСУ дахь Гёте-Институтээс 6 улсын 7 хотод (Сөүл, Токио, Бээжин, Шанхай, Тайпэй, Хонконг, Улаанбаатар) хэрэгжүүлж байна. Технологи, урлагийг хослуулсан 7 хотоор хийх аяллыг нэгдсэн байдлаар Гёте-Институтийн цахим платформ дээр 11 дүгээр сард толилуулна. Бидний хувьд төслөө “Тал нутгийн хотыг нээхүй” буюу “Exploring the City on the Steppes” гэж нэрлэсэн.

Э.Эрдэнэ: Урбан Волкс төсөл нь Улаанбаатар хотын иргэдэд амьдарч буй хоттойгоо ахин танилцаж, хотын амьдралыг шинээр харах боломжийг олгох зорилготой төсөл юм. Төслийг Монгол дахь Гёте-Институт, Монголын Урлагийн Зөвлөл, Улаан гэр арт галерей дэмжин ажиллаж байгаа.

Ингэхэд Б.Мэнд-Амар, Э.Эрдэнэ гэж ямар хүмүүс вэ гэдгийг уншигчид сонирхох нь лавтай. Мөн яагаад энэ төслийг эхлүүлэх болсон бэ?

Б.Мэнд-Амар: Би МУИС-ийг мультимедиа график дизайнер мэргэжлээр суралцаж төгссөн. “Монгол дүрслэмж” ТББ-ын тэргүүн. Улаанбаатар хоттой холбоотой судалгаа, төслүүдэд голчлон ажилладаг. Цахим орчинд С.Цэрэндолгортой хамтран үүсгэн байгуулсан Mongolian Visuals хуудсыг хөтлөхийн сацуу гэрэл зурагчин Б.Бат-Оргилтой хамтран “Улаанбаатараас ярьж байна - Live from Red Hero” подкастыг хөтлөн хүргэдэг.

Э.Эрдэнэ: Би кино найруулагч мэргэжлээр ВГИК-ийг төгссөн. Улаанбаатар хотын унаган иргэн. Мэндээтэй анх “Урлагийн залуу манлайлагч” хөтөлбөрт оролцож танилцсан. Хоёулаа хотын түүхийг сонирхон судлах дуртай учраас энэ төсөлд хамтдаа оролцох болсон юм.

“Урбан Волкс” төсөл дээр хэд хэдэн байршлыг сонгосон байсан. Тэдгээр байршлыг чухалчлан сонгож авсан шалтгаанаа тайлбарлана уу?

Э.Эрдэнэ: Гандангаас Сүхбаатарын талбай хүрэх маршрут нь зөвхөн Улаанбаатарын гэлтгүй Монгол Улсын XX, XXI зууны туулж өнгөрүүлсэн түүхийг тэр чигээр нь багтааж чадсан чиглэл учраас онцлон сонгосон.

Б.Мэнд-Амар: Энэ чиглэлийн дагуу байрлах гудамж, барилгууд нь 100 гаруй жилийн тэртээгээс анх Хүрээ хот болон худалдааны гудамж бий болсон Богд хааны үе буюу феодализмаас социализмын үе, наашлаад ардчилсан нийгэмд одоо ч оршсоор буй анхны гэх тодотголтой түүхэн барилгууд юм. Жишээлбэл: Анхны ресторан Туул, анхны Их дэлгүүр буюу Өндөр хоршоо, анхны Хоршоолол, үйлчилгээний нэгдсэн төв буюу буюу Урт цагааны гудамж зэрэг нь энд байдаг. Мөн Гандангаас Сүхбаатарын талбай хүртэлх орон зайгаар дамжуулан Улаанбаатар хотын өнгөрсөн 100 гаруй жилийн түүхэн цаг үеийн хувирал өөрчлөлт, онцлогийг таньж мэдэх, мэдрэх боломжтой гэдгээрээ онцлог.

Энэ төслөөр яг юунд хүрэхийг зорьж байгаа вэ?

Э.Эрдэнэ: Улаанбаатар хотын музейн судлаач Г.Очбаярын хэлдэгчлэн хот бол яах аргагүй бидний гэр мөн. Гэтэл одоо байгаа Улаанбаатар хот маань гэр шиг таатай, тухтай мэдрэмж төрүүлж чадахгүй байгаатай хүмүүс маргахгүй байх. Алхам тутамд ямар нэг стресс үүсгэх зүйл бидэнтэй тааралдаж байна. Бид “Тал нутгийн хотыг нээхүй - Exploring the City on the Steppes” төслөөрөө хүмүүст төрөлх хотынх нь үнэ цэнийг дахин сануулж, их хотоо хайрлах хүслийг Улаанбаатарчуудын сэтгэл дотор бадраахыг хүссэн. Хотын иргэд, хот хоёр салшгүй нягт холбоотой шүү дээ.

Б.Мэнд-Амар: Улаанбаатар хот дэлхийн хамгийн хүйтэн нийслэл хот. Бас уламжлалт гэр болон орон сууц хосолсон байдлаараа онцлог. Социализмын үеийн хот төлөвлөлтөөр хамгийн ихдээ 500 мянган хүн амаас хэтрэхгүй байхаар

төлөвлөгдсөн ч нийгэм, эдийн засгийн хөгжил, дэд бүтэц, хөдөө орон нутгийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор аль хэдийн 1.4 сая хүн амтай том хот болж хувирахдаа хот төлөвлөлт, унаган дүр төрх, гоо зүй нь нэлээд алдагдсан. Бид төслөөрөө дамжуулан хотын түүхэн гудамж болон барилгууд, тэдгээрийн онцлог шинжийг Монголын шинэ залуу үе болон бусад гадна дотнын жуулчдад таниулах, хотын амин сүнс, дүр төрхийг хоногшуулах, цаашлаад уг төслөөр дамжуулан хотын соёлыг түгээхийг зорьсон.

Төслийн үр дүнг хэрхэн төсөөлж байгаа вэ?

Э.Эрдэнэ: “Тал нутгийн хотыг нээхүй – Exploring the City on the Steppes” төсөл маань 3 үе шаттай. Эхнийх нь явган аялал байсан. Бид Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяртай хамт Гандангаас Сүхбаатарын талбай хүртэл 3 цагийн явган аяллыг 8 дугаар сард зохион байгуулсан. Ингэснээрээ хүмүүс өөрсдийн нүдээр хотоо хэрхэн өөрчлөгдсөнийг харах боломж бий болж байгаа юм. Хоёр дахь шат нь гэрэл зураг болон видео хосолсон үзэсгэлэнг сая 10 дугаар сард толилуулсан.

Үзмэрүүдээ Гандангаас Сүхбаатарын талбай хүртэлх маршрутын дагуу тааралдах барилга, байршилтай холбоотой архивын гэрэл зураг болон видео бичлэгээр бүрдүүлсэн юм. Энэ нь хүмүүст сонирхолтой санагдсан гэж найдаж байна. Чингэхдээ бид зөвхөн архивын дүрс ашиглаагүй гэдгээ хэлэх нь зүйтэй байх. Тодорхой гудамжинд байрлах барилгуудын онцлогийг Улаанбаатар хотын нэр бүхий иргэдээс ярилцлага авах замаар тайлбарлуулсан. Байршил болгоны хажууд бид QR код нааж үзэсгэлэнгээр зочилсон хүн бүрд тухайн барилга, байшинг өнөө цагт байгаагаар нь 360 хэмийн камераар харах боломж олгосон юм.

Б.Мэнд-Амар: Эцэст нь маршрутын дагуух барилга байгууламжтай холбогдох тодорхой дүрүүдийг төлөөлүүлэн ярилцлага хэлбэрийн богино хэмжээний видео бүтээлийг толилуулах юм. Бид фото сурвалжлагч Л.Санжмятав; Шөнийн галт тэрэг хамтлагийн дуучин, соёлын өвийн мэргэжилтэн М.Цэцэнбилэг; Урт цагааны үсчин З.Уранчимэг; Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр; Финландын сэтгүүлч, продюссер Ирья Халаш; архитектор, хотын антропологич С.Амгалан зэрэг нэр бүхий зочдыг урьж оролцуулсан.

Төслийн үр дүнд бидний бүтээл аль болох олон хүнд хүрвэл сайхан ч түүнээс илүүтэй том зургаар харвал Улаанбаатар хотын түүхэн гудамж, талбай, барилга, байгууламж, дурсгалыг хадгалж хамгаалах тал дээр иргэд нэгдмэл байр суурьтай байгаасай гэж хүсэж байна. Жишээ нь манай маршрутын нэг хэсэг болох Урт цагааныг нураагаад оронд нь өндөр шинэ барилга барих талаар мэдээлэл сүүлийн үед нийгэмд эрчимтэй яригдах боллоо. Үүнд иргэд төрөл бүрийн байр суурийг илэрхийлж байгаа нь анзаарагдсан бөгөөд хүмүүсийн ялгаатай үзэл санааг хүндэтгэх нь зүйн хэрэг. Үзэгчид бүтээлийг зүгээр

үзэж сонирхоод л өнгөрөх биш хотынхоо унаган дүр төрхийг хадгалах замаар хэрхэн нийт иргэд, оршин суугчдад ээлтэйгээр сайжруулж болох вэ гэдэг асуулыг цаашид өөрсдөөсөө асуугаасай, эргэцүүлдэг байгаасай. Энэ нь төслийн үр дүнгээр хязгаарлагдахгүй чухал юм болов уу.

“Урбан Волкс” хотын аялал цаашид бүх насныханд зориулсан хотын аялал байдлаар үргэлжлэн явагдах уу?

Э.Эрдэнэ: Мэдээж бидний хувьд энэ төслийг цаашид үргэлжлүүлэх нь чухал юм. Ирэх зун шинэ маршрут сонгож, илүү олон оролцогчтойгоор явган аялал зохион байгуулах хүсэлтэй байгаа.

Б.Мэнд-Амар: Бид тус төслийн дараа ч гэсэн үргэлжлүүлэн Улаанбаатар хотод төрөл бүрийн маршрутыг танилцуулах аяллыг тодорхой мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулахыг чин сэтгэлээсээ хүсэж байна.

Эцэст нь хотын аль хэсэгт илүү дуртай вэ? Яагаад?

Э.Эрдэнэ: Миний хувьд 3, 4 дүгээр хороолол очих дуртай газруудын минь нэг байсаар ирсэн. Бага насаа тэнд өнгөрүүлсэн учраас олон сайхан дурсамж минь тэр газар хоногшиж үлдсэн. Хотын булан тохой болгон хүмүүсийн дурсамжаар дүүрэн байдаг гэдэгт би итгэдэг. Тийм ч учраас хотын иргэн байна гэдэг нь тэр дурсамжийг хүндэтгэн хайрлахын нэр гэж бодож байна.

Б.Мэнд-Амар: Надад Хан-Уул дүүргийн 120 мянгат болон хотын төв хэсэг болох 220 мянгат, 40 мянгат, УИД, Улсын цирк орчим их таалагддаг. Мөн нийтийн тээврээр буюу 7, 8 дугаар



чиглэлийн троллейбус явдаг байсан долоон буудал, баянбүрдийн тойрог, тасганы овоо, сансрын тойрог болон бусад хотын захын дүүргүүдээр очиж тухайн хэсгийн ялгаа, онцлогийг бага насны дурсамжууд дээр тулгуурлан харьцуулж мэдрэх нь их таатай байдаг.

Учир нь хойноос урагшаа хэдхэн км дотор орчин үеийн өндөр барилга, социализмын үеийн орон сууц, гэр хороолол, зуслангийн бүсийн айл өрхүүдийн маш ялгаатай дүр төрх зэрэгцэн оршин байдаг нь маш этгээд, донжтой санагддаг юм.

Энэ төслийн талаар дэлгэрүүлэн мэдье гэвэл хаанаас мэдээлэл авч болох вэ?

Э.Эрдэнэ, Б.Мэнд-Амар: Манай төслийн талаар Urban Walks Mongolia нэртэй Инстаграм болон YouTube сувгаас дэлгэрэнгүй мэдээлэл авч болно. Түүнчлэн Монголын Урлагийн Зөвлөл болон Монгол дахь Гёте-Институтийн цахим хуудаснаас мэдээлэл авах боломжтой. Мөн ярианы эхэнд дурдсанчлан төслийн онцлог нь Улаанбаатар хоттой нийлээд Зүүн Азийн нийт 7 хотын уран бүтээлчид 11 дүгээр сард тус тусын бүтээлээ эцсийн байдлаар Гёте-Институтийн нэгдсэн платформ буюу www.goethe.de/urbanwalks цахим хуудас дээр танилцуулах юм. Ингэснээрээ тус бүтээлүүдийг дэлхийн хаанаас ч чөлөөтэй үзэж сонирхох боломжийг олгож байгаа.



EXPLORING THE CITY ON THE STEPPES





**URBAN
WALKS**
Spaziergänge in der Stadt



**GOETHE
INSTITUT**



Illustration: Uuganbaatar Munkhbat





Amarone della Valpolicella нь удаан хадгалагдах чадвараараа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Италийн хамгийн алдартай шилдэг дарснуудын нэг.

Amarone della Valpolicella нь DOCG буюу Итали дарсны чанарын хамгийн өндөр үзүүлэлт, стандартыг хангасан улаан дарс бөгөөд зөвхөн Италийн Verona мужийн Valpolicella хотод үйлдвэрлэдэг.

Хамгийн сайн усан үзмийн багцыг гар аргаар сонгож, 100 хоногийн турш хатаах үед усан үзм өөрийн жингийн 40 орчим хувийг алддаг. Хатаасан усан үзмийг температурын хяналттай зэвэрдэггүй ган саванд мацерациягаар исгэж энэхүү дарсыг үйлдвэрлэдэг.

Байгальд ээлтэй аргаар хийсэн ДАРС

AMARONE DELLA VALPOLICELLA-DISCIPLINARY
OF AMARONE DELLA VALPOLICELLA

Хаяг: Monte Vino, Монгол Улс, Улаанбаатар хот,
1 дүгээр дөчин мянгат, Цэцэг төвийн уулзвар
www.montevino.mn





AMARONE DELLA VALPOLICELLA-ИЙН ТОВЧ ТҮҮХ

Амарон нь санамсаргүй алдааны үр дүнд бий болжээ:

Энэ нь исгэх процессыг андуурч дуусгаж, улмаар бүх элсэн чихрийг архи болгон хувиргаснаар зоорины эздийн хяналтаас гарсан Valpolicella(Recioto)-ийн амтат улаан дарснаас гаралтай. Иймээс андуурч төрсөн эдгээр дарс нь Recioto-аас хамаагүй илүү танник, гашуун байсан бөгөөд "recioto scapa" гэж тодорхойлсон байдаг. Хожим нь энэ хэв маягийг 1936 онд Cantina Sociale Valpolicella Negrar-ийн түлхэц, Бертанигийн оруулсан хувь нэмрийн ачаар кодчилж, боловсронгуй болгосон юм.

Италийн шилдэг дарсуудын нэг болох орчин үеийн Amarone della Valpolicella 1960-аад оны үеэс дэлхий даяар үнэлэгджээ.

- Усан үзэм хатаах аргыг анх Amarone della Valpolicella-д нэвтрүүлсэн бөгөөд энэ нь өнгө, үнэр, бүтцийг төвлөрүүлж, өвөрмөц шинж чанартай, цогц, олон талт, ер бусын гоёмсог дарсыг гаргаж авах зорилготой байсан юм.

- Amarone della Valpolicella нь зөвхөн Corvina Корвина /45-95%/ ба /эсвэл Corvinone Корвинон /45-95%/, Rondinella Рондинелла /5-30%/ болон бусад төрлийн үнэрт бус улаан усан үзмийн сортуудаар үйлдвэрлэгддэг.

- 500 литрээр нь 24 сар дардаг. Францын царс модны торхонд 18 сарын турш дунд болон том хэмжээтэй славян царс модны саванд исгэдэг. Түүний дараа 12 сарын турш лонхонд боловсорч гүйцнэ.

- Амарони дарсны насжилт дээр маш их анхаардаг ба 12 дугаар сарын 1-нээс өмнө хатааж орхисон усан үзмийг дарсжуулах, ургац хураалтын дараа 3 дахь жилийн 1 дүгээр сарын 1-нээс өмнө үйлдвэрлэсэн дарсыг зах зээлд гаргах боломжгүй гэж заасан. Гэсэн хэдий ч олон үйлдвэрлэгчид дарсыг зах зээлд гаргахаасаа өмнө хөгшрөлтийн хугацааг уртасгах хандлагатай байдаг байна.



1. УРГАЦ ХУРААХ

Амароныг үйлдвэрлэхэд ашигладаг усан үзмийн ургацыг гараар хураадаг бөгөөд ихэвчлэн 9 дүгээр сарын сүүлээс 10 дугаар сарын эхний долоо хоногийн хооронд боловсордог.

2. APPASSIMENTO

Ургац хураалтын дараа усан үзмийг 4 сар хүртэл арел эсвэл Фруттай хэмээх агааржуулалттай өрөөнд хатаана.

3. БУТЛАХ

Аппассименто дууссаны дараа усан үзэм бүр жингийнхээ 40 орчим хувийг алдсан байдаг. Ийм үед нь буталдаг.



ДУГУЙЧДАД ХҮЛЭЭЦТЭЙ ХАНДАЖ БАЙГААРАЙ



Нийтлэлийг: **О.УДВАЛ**
Тогтвортой тээврийн мэргэжилтэн
MSc in Sustainable Transport

Маршалын гүүрнээс Скай ресорт руу машинаа бариад явж байхдаа машин замаар шахцалдах унадаг дугуйтай хүмүүсийг хараад та дургүйцдэг үү? Хажууд нь бэлхэн дугуйн зам байсаар байхад машин замаар явлаа гэж та боддог уу? Тэгвэл энэ нийтлэлийг заавал уншаарай. Магадгүй таны бодол өөрчлөгдөж, дараагийн удаа та дугуйчидтай таарахдаа арай хүлээцтэй хандах байх.

Энэ дугуйн замаар дугуйчид дугуйгаа унахгүй амь насаа эрсдэлд оруулан байж яагаад машин замаар яваад байгааг тайлбарлахаас өмнө дугуйн зам барихад баримтлах гол зарчмын талаар товчхон дурдъя. Энэ нийтлэлд дугуйн зам буюу бусад замаас биет байдлаар тусгаарлагдсан замыг авч үзэж байгааг анхаарна уу. Унадаг дугуйн эгнээ буюу автомашин, явган хүний замтай хувааж хэрэглэдэг эгнээ үүнд хамаагүй болно.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Явган зорчигчид, автомашинтай замаа хуваахгүй, тусдаа зориулалтын дугуйн зам байхаас гадна, гэрэлтүүлэг, уулзвараар давуу эрх эдлэх тэмдэглэгээ болон гэрлэн дохиотой байх. Замын аюулгүй байдлыг хангах үүднээс эвдрэл, гэмтэл, нүхгүй арчилгаа сайтай байх.

ШУУД ЯВАХ БОЛОМЖ

Шууд явах боломж буюу дугуй унаж байх үед дундаа зогсох зогсолтыг аль болох хамгийн багатай саад тотгоргүй зорчих боломжоор хангах. Дугуй унах үед

жигд хурдаар явах маш чухал. Хэрэв ямар нэг саад учирснаас зогссон бол дахин жийж эхлэхэд жигд хурд руу ортол илүү хүч шаардагддаг.

ХҮМҮҮСИЙГ ТАТАХ

Дугуй унах сонирхлыг төрүүлэхүйц харагдах байдал сайтай дугуйн замаа сонгож барих. Жишээ нь, голын эргээр, модны сүүдэр дагуу гэх мэт.

ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ

Дугуйн замын сүлжээний мэдээллээр сайтар хангах, ингэснээр дугуйчин өөрийн

явах замаа урьдчилан тооцоолно. Дугуйн зогсоол, амрах газрыг барьж өгөх. Тэмдэг тэмдэглэгээг ойлгомжтой байдлаар, хангалттай байршуулах.

Дугуйн замын стандартын хувьд манай улс олон улсын стандартуудаас эш татан авсан MNS 5683:2016 "Замын байгууламж. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих шаардлага" гэсэн стандартыг мөрддөг. Дараах хүснэгтээр энэ стандартыг олон улсын стандарт болон практикт хэрэгжилтийг харьцуулан харууллаа.

Бид стандартын хэрэгжилтийг харьцуулж үзсэн бол одоо Маршалын гүүрнээс Скай ресорт хүртэл үргэлжилсэн 9.5 км дугуйн замаар явахад дугуйчдад тулгарч буй асуудлуудыг дор дурдлаа. Эдгээр зургуудыг амралтын өдрийн өглөө 9 цагийн үед буюу авто замын хөдөлгөөн харьцангуй бага байхад авсан болно.



1. Дугуйн замын эхэнд болон замын гадаргуу дээр дугуйн зам эхэлж байгааг илтгэх тэмдэг, тэмдэглэгээ байхгүй.



2. Дугуйн зам тасарч машин замтай нийлэх эсвэл шороон зам руу ордог. Дугуйн зам 5-аас дээш удаа тасардаг.



3. Энэ тохиолдолд машин зам руу орохоос өөр аргагүй боловч машин замтай нийлж байгааг дугуйчид болон жолооч аль алинд нь анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ байхгүй. Мөн хурдтай явж байгаа тохиолдолд энэ хайрга руу дугуйтай орох нь осолдох эрсдэлийг маш өндөр болгодог. Нэг бол зогсож араас ирж буй машиныг харах, эсвэл явах замдаа эргэн харж байгаад, зам руу нийлэх сонголт дугуйчдад тулгардаг ба энэ нь осолд өртөх хамгийн өндөр эрсдэлтэй хэсэг.

4. Машинууд зам хааж зогссон байдаг. Дугуйн зам, машин зогсохыг хориглоно гэсэн тэмдэг огт байхгүй.

Замын хажууд нүх гарч, дугуйн замын өргөнийг нарийсгаж, 2 дугуй зөрөх боломжгүй болсон бөгөөд, үүнийг анхааруулсан тэмдэггүй. Энэ хавьд мөн гэрэлтүүлэггүй. Хажуу талаас шороо болон нуранга нурах эрсдэлтэй. Замын аль ч хэсэгт гэрэлтүүлэггүй бөгөөд машин замын нөгөө талд байгаа гэрэл дугуйн замыг хангалттай сайн гэрэлтүүлж чаддаггүй.



Энэхүү дугуйн зам нь өөрөө стандартын бүрэн шаардлагыг хангаагүй, байнгын арчилгаа хийгддэггүйгээс дугуй унахад дээрх олон эрсдэлийг дагуулдаг тул жолооч та дараагийн удаа дугуйн замаараа явсангүй гэж дугуйчдыг бүү зэмлээрэй. Энэ зам нь ялангуяа, засмал замын дугуй буюу 23 мм-ийн өргөн зай нь дугуй унахад тун тохиромжгүй.

Мөн та хотын бусад машин замаар яваа дугуйчдад хүлээцтэй хандаж байгаарай. Учир нь Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэмд “унадаг дугуйн эгнээ” гэж зорчих хэсэг дээрх унадаг дугуй, мопедын хөдөлгөөнд зориулсан, 4.4 тэмдэг бүхий эгнээг хэлнэ. Унадаг дугуйн эгнээ нь зорчих хэсгийн бусад эгнээнээс тэмдэглэлээр зааглагдсан

байна. Унадаг дугуйн зам болон унадаг дугуйн эгнээ байхгүй, эсхүл түүгээр явах боломжгүй тохиолдолд зорчих хэсгийн баруун гар талын захаар байрлан явж болно” гэж заажээ. Харамсалтай нь энэ заалтыг тээврийн хэрэгслийн жолооч тэр бүр мэддэггүйгээс унадаг дугуйгаар зорчигчидтой зорчих хэсгийг хуваалцахдаа сөрөг хандлагатай байдаг.



	ОЛОН УЛСАД	МОНГОЛД	СКАЙ РЕСОРТЫН ЗАМ Маршалын гүүрнээс Скай Ресорт хүртэл үргэлжилсэн 95 км дугуйн зам
 Хашилт	Дугуйн замын өргөн 2 дугуйтай хүн зэрэгцээд явахад хангалттай буюу багадаа 2 метрийн өргөнтэй байна.	Унадаг дугуйгаар явахад зориулагдсан зохих тэмдгээр тэмдэглэгдсэн зам. Бусад замаас хийцийн хувьд тусгаарлагдсан байна. Замын өргөн 1м - 2м байна.	Дугуйн замын 2м өргөнтэй, хамгийн нарийн хэсэг нь 12 метр байна.
 Тэмдэглэгээ	Зам дээр будгаар дугуйн зам гэдгийг тодорхой тэмдэглэсэн байна. Дугуйн зам эхлэх гэж байгааг жолооч нарт мэдэгдсэн тэмдэглэгээ, мөн дугуйн зам дуусах буйг дугуйчдад мэдэгдсэн тэмдэглэгээ байхаас гадна дугуйн зам машины замтай нийлэх бүрт тэмдэглэгээ тавина. Уулзварууд дээр дугуйнд давуу эрх олгох буюу уулзвараар түрүүлж гарах тэмдэглэгээ тавина. Дугуйн зам дээр автомашин тавихыг хориглоно гэсэн тэмдэг байна.  Зураг 1. "Автомашин зогсохыг хориглоно" тэмдэг  Зураг 2. Уулзвараар дугуйчдад зам тавьж өгөөд баруун эргэх тэмдэг	Унадаг дугуйн зам, эгнээг MNS 4597: 2014 "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" стандартад заасан 4.4 "Унадаг дугуйн зам" тэмдгээр тэмдэглэнэ. Тэмдгийг унадаг дугуйн замын эхэнд байрлуулах ба замтай огтолцсон бэлчир бүрийн дараа давтан тавина. Замын гадаргуу тэмдэглэгээ хийж болно. Замын зорчих хэсэгтэй огтолцсон унадаг дугуйн замын бэлчир бүрийн дараа 4.4 тэмдгийг давтан тавина. 4.4  Монгол Улсад хэрэглэгдэж буй тэмдэг	Байхгүй
 Гэрэлтүүлэг	Чанар муутай баригдсан зам, эсвэл бартаа ихтэй замд гэрэлтүүлэг байх нь маш чухал.	Заалтгүй	Байхгүй
 Тэгшхэн буюу овон товонгүй /нүх эвдрэлгүй байх/	Дугуйчны зарцуулах хүчин чадал нь дугуйн замтай шууд хамааралтай. Сайн чанартай хучилттай засмал зам дээр явснаас 30-40% илүү хүчийг блокон гадаргуутай явган хүний зам дээр, шороон зам дээр 50-100% илүү хүчийг дугуй унаж буй хүн зарцуулдаг. Овон товон, нүх гэх мэт гэмтэлтэй зам дээр дугуйчин осолд өртөх магадлал нь илүү. Дугуйтай хүн 2 нарийн дугуйн дээр тэнцвэрээ олж, тогтож явдаг тул машинтай харьцуулахад бартаатай зам дээр осолдох илүү эрсдэлтэй. Дугуйн зам нь ямар ч төрлийн дугуйгаар явж болохоор байх хэрэгтэй. Жишээ нь, замын дугуй, уралдааны дугуй буюу маш нарийн дугуйтай дугуйнууд.	Заалтгүй	Маш их овон товон, чулуу, шороотой.
 Замын ямар нэгэн саадгүй байх	Дугуйн замыг барихдаа дугуй унаж буй хүн 1 км-т 0,4 удаа буюу 4 км-т 1 л удаа зогсох дизайны зохион байгуулалттай байна.	Заалтгүй	Машинзамтай нийлдэг багадаа 5 хэсэгтэй тул аюулгүй байдлын үүднээс багадаа 5 удаа зогсож, араас ирж буй машиныг харах шаардлагатай. Энэ нь км бүрт 1 зогсолт болж байна.



Байгальд ээлтэй “GREEN MARATHON”

Сүүлийн үед олон нийтийг хамарсан аливаа арга хэмжээ, зохион байгуулалт нь тогтвортой байдлыг эн тэргүүнд тавьж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгахын тулд улам бүр “ногоон” хандлагатай болж байна.

Байгальд ээлтэй туршлагыг нэвтрүүлэхийн сацуу оролцогчид, үзэгчид, зохион байгуулагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд түлхэц өгөх, тогтвортой хөгжлийн төлөөх зан үйлийг хэвшүүлж төлөвшүүлэхийг зорьж байгаа нь чухал ахиц дэвшил юм. Зориг сангийн 13 дахь удаагийн “Байгаль орчны манлайлал” хөтөлбөрт оролцогч залуус энэ чиглэлд нэгэн чухал төсөл хэрэгжүүлсэн нь Green Marathon. Уг төслөөр жил бүр зохиогддог Улаанбаатар олон улсын марафоны зохион байгуулалтыг байгальд ээлтэйгээр шийдэх зорилго тавьж, “Хай Пеймэнт Солюшнс” ХХК болон Нийслэлийн биеийн тамир, спортын газартай хамтран ажиллажээ. Улаанбаатар марафон нь жилээс жилд өргөжин, оролцогчдын тоо нэмэгдсээр байна. Анх 16839 оролцогчтой байсан бол жил бүр нэмэгдсээр, 2019 онд 30 мянга хүрч байжээ. Энэ жилийн хувьд 100 гаруй аж ахуйн нэгж, 500 гаруй сайн дурын ажилтан, 30 орны 20 мянга гаруй хүн оролцсон байна.

Green Marathon төслийн үр дүнд марафоноос гарсан хуванцар савыг анхдагч эх үүсвэр дээр цуглуулж, дахин боловсруулах цэгт хүргэжээ. Нийт **8890** ш буюу **166.4** кг хуванцар хаягдлыг Зеровеист клубтэй хамтран цуглуулсан байна.

Мөн цуглуулсан **8890** ширхэг хуванцараар **330** ширхэг цамц, **808** ширхэг дунд хэмжээний үүргэвч үйлдвэрлэх боломжтой юм байна. Түүнчлэн Улаанбаатар марафонд ашиглахаар төлөвлөж байсан нэг удаагийн хуванцар аяаны хэрэглээг зогсоож, 100% ургамлын гаралтай байгальд 90 хоногийн дотор задардаг “Борду” брэндийн **5000** ш био аяга ашиглажээ. Өөрөөр хэлбэл 16 кг хуванцар нэг удаагийн аяаны хэрэглээг зогсоосон төдийгүй хэрэглэсэн био аягаа Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, ногоон өнгө нэмж буй “Ойм ногоон урлан”-д ургамлын үрсэлгээний зориулалтаар хүлээлгэн өгсөн.

Байгальд ээлтэй санаачилга, үйл ажиллагааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Сүхбаатарын талбайд “Ногоон асар” барьж “Өнгө нэм” ТББ-тай хамтран хуванцар хог хаягдлын шинж чанар, дахин боловсруулахын ач холбогдлыг таниулжээ. Ийнхүү Green Marathon төсөл нь бүхий л төрлийн өдөрлөг, үйл ажиллагаанаас оролцогчдын тооноос хамааран олон тооны хуванцар хаягдал гардаг тул түүнийг байгальд ээлтэйгээр шийдэх боломжтойг харуулсан юм. Цаашлаад тогтвортой ирээдүйг бий болгоход хувь нэмрээ оруулж, олон нийтийг хамарсан спортын арга хэмжээний салбарт эерэг өөрчлөлт, санаачилга авчрахад томоохон алхам болсон байна.



Зориг сангийн 13 дахь удаагийн “Байгаль орчны манлайлал” хөтөлбөрт оролцогч залуус энэ чиглэлд нэгэн чухал төсөл хэрэгжүүлсэн нь Green Marathon юм.



УЛААНБААТАР ХОТ

ЯВГАН ЗОРЧИХ ЦЭЦЭРЛЭГТ ХОТ



Ногоон корридорын төлөвлөгөө, 1975.

Аливаа хотын амьдрах орчны чанарт орон сууцны төлөвлөлт чухал үүрэгтэй байдаг.

1.6

сая

Улаанбаатар хот нь 2023 оны байдлаар 1.6 сая хүн амтай байна.

850

мянга

Дээд тал нь 850,000 хүн ам амьдрах зориулалтаар төлөвлөсөн хот тул орон сууцны хүртээмжийг нэн тэргүүнд сайжруулах шаардлага тулгараад байна.



Нийтлэлийг: **Э.МИНЖМАА**
Мэргэшсэн архитектор (МАЭ)
Архитектурын шинжлэх ухааны Магистр
(KTH) Royal Institute of Technology

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь нийт газар нутгийн ердөө 0.3%-ийг эзэлдэг ч нийт хүн амын бараг тал хувь нь оршин суудаг. 35 мянга орчим га талбайг хамардаг Улаанбаатар хот нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 9 дүүрэг, дүүрэг нь хороодод хуваагдана. Хороо нь хэсгийн зохион байгуулалттай. Дэлхийн бусад хотуудын адилаар хүн амын тоо хурдацтай өсөн нэмэгдэж, хэт төвлөрөл бий болж буй хот юм.

Монгол Улс 1992 онд чөлөөт эдийн засагт шилжсэнээс хойш барилгын бүтээн байгуулалт эрчимжсэн нь нийслэл Улаанбаатар хотын төлөвлөлтөд нөлөөлж, асар ихээр өөрчилж байна. Хүн амын хэт төвлөрлийг дагаад агаарын бохирдол ихсэж, авто замын түгжрэл нэмэгдэх, ногоон байгууламжийн хүрэлцээ хангамж буурах зэрэг нийгмийн сөрөг асуудлууд үүссээр байна. Олон нийтийн зүгээс эдгээр асуудлыг цэгцэлж, дорвитой арга хэмжээ авахыг байнга сануулан шүүмжилж ирлээ. Иргэдийн ийм идэвхтэй оролцоо нь нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн талбайнуудыг олноор бий болгох, амьдрах орчныг сайжруулж, нийгмийн эрүүл мэнд болон хүнд ээлтэйгээр төлөвлөж, хөгжүүлэхийн үндэс болох сайн талтай юм.

Улаанбаатар хот нь 1911-1998 онд батлагдсан хэд хэдэн хөгжлийн төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжиж байна. Тэдгээрээс Улаанбаатар хотын төлөвлөлтөд хамгийн их нөлөөлсөн нь Ногоон коридорын төлөвлөгөө.

Эбэнэээр Ховардын 1898 онд анх гаргасан Цэцэрлэгт хотын хөдөлгөөний нөхцөлүүдийг шингээсэн Ногоон коридорын төлөвлөгөөний дагуух төлөвлөлтийг Улаанбаатар хот 1975 онд баталсан байдаг. Уг төлөвлөлт нь орон сууц, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн талбай бүхий цэцэрлэгт хот байдлаар төлөвлөгддөг онцлогтой. Энэхүү концепцийн дагуу анхны цэцэрлэгт хотыг Английн Летчворт хотод байгуулжээ. Энэ нь хотын төвийг илүү онцгойлж авч үзэн, нийтийн эзэмшлийн ногоон талбай ихтэй,





Улаанбаатар хотын агаараас авсан зураг, 1980.



Летчворт хотын агаараас авсан зураг, Англи улс 2009.

нийтийн тээврийн систем бүхий алхахад таатай орчинтой байхаар төлөвлөдөг онцлогтой. ХБНГУ-ын Хэллэрау зэрэг цэцэрлэгт хотуудын адилаар эдийн засгийн үр ашгаас илүүтэйгээр нийтэд зориулсан нийтийн эзэмшлийн талбайнууд бүхий тээврийн системд анхаарч, Веймарын үеийнх шиг амины орон сууцны төлөвлөлтийн суурийг тавьсан байдаг.

Аливаа хотын амьдрах орчны чанарт орон сууцны төлөвлөлт чухал үүрэгтэй байдаг. Улаанбаатар хот нь 2022 оны байдлаар 1.6 сая хүн амтай байна. Дээд тал нь 850 мянган хүн ам амьдрах зориулалтаар төлөвлөсөн хот тул орон сууцны хүртээмжийг нэн тэргүүнд сайжруулах шаардлага тулгараад байна. Орон сууцны бүтээн байгуулалтыг өнөөдөр хувийн хэвшлийн төлөвлөгөө ч гэсэн ашиг орлогын үр ашигтай байдалд илүүтэй анхаарч байна. Түүнчлэн барилга байгууламжууд нь дэд бүтцээ дагаад хотын төвдөө түлхүү төвлөрч байна. Өндөр барилгууд ихээр баригдаж буйн улмаас ногоон байгууламжийн тоо хэмжээ улам бүр цөөрч хумигдсаар байна.

Социалист нийгмийн үед баригдсан орон сууцнуудын хувьд илүүтэй нийгмийн хэрэгцээг хангах байдлаар төлөвлөгдсөн байдаг. Барилгын гаднах болон тоглоомын талбай, хүүхдийн цэцэрлэг, сургууль, нийтийн тээвэрт ойр байдлаар орон сууцнуудын төлөвлөлт хэрэгжсэн.

Өнөөдөр Улаанбаатар хотод хувийн хэвшлийн барьсан орон сууцнуудад тулгарч буй асуудлын нэг нь арчилгаа, цэвэрлэгээ юм. Барилгын зохион байгуулалтыг эхнээс нь зөв сайн тооцоолоогүйн улмаас халаалт, ус, хог хаягдлын системийн хувьд тун тааруухан нөхцөлд байна. Мөн эдгээр орон сууцны барилгууд нь өнөөгийн эрчим хүчний үр ашигтай

байдлын стандартыг хангаж чадахгүй байгаа.

Улаанбаатар хотод гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслөөр гэрийн хорооллыг барилгажуулж, орон сууцаар хангах төлөвлөлт хэрэгжиж байна. Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх энэхүү дэд хөтөлбөр нь нээлттэй дахин төлөвлөлтийн төслийн журмаар иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхээр Засгийн газраас явуулж буй дунд хугацааны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжиж буй юм.

Үүнд тулгарч буй гол асуудал нь социалист нийгмийн



Улаанбаатар хотын агаараас авсан зураг, 1970.



Хеллерау хотын агаараас авсан зураг, Герман улс 1907.

үед бүтээн байгуулсантай ижил хэмжээгээр орон сууцыг олноор байгуулах зай талбайн боломжгүй тул хотын ойролцоох бүсүүдэд орон сууцны томоохон бүтээн байгуулалтуудыг эхлүүлсэн явдал. Гэвч эдгээр газруудад нийтийн тээврийн сүлжээ хангалтгүйн улмаас иргэдийн хувийн тээврийн хэрэгслүүд ихээр ашиглагдаж байна. Үүнээс үүдэлтэйгээр замын түгжрэл, агаарын бохирдол, цаашлаад иргэдийн хэт таргалалт зэрэг нийгмийн сөрөг асуудлууд үүсэх болсон билээ.

Нийтийн тээврийн нэгдсэн системийн хувьд явган

зорчиход таатай байдлаар явган хүний замыг сайжруулж, унадаг дугуйн замыг нэмэгдүүлэх нь түгжрэлийг бууруулах нэг шийдэл юм.

Түүнчлэн шаардлагатай дэд бүтэц хомсын улмаас гэрийн хороолол улам бүр тэлсээр байна. Хатуу түлш буюу нүүрсээр халаадаг гэрийн хороолол нэмэгдэж байгаа нь Улаанбаатар хотын агаарын бохирдлыг үүсгэж буй голлох шалтгааны нэг. Улаанбаатар хотын агаарын бохирдлын хэмжээ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн түвшнээс хэдэн арав дахин даваад байгаа.

Хямд үнэтэй, тогтвортой орон сууцны тусламжтайгаар гэрийн хорооллын тэлэлтийг хязгаарлахаас гадна илүү олон айл өрхийг дэд бүтцэд холбосноор агаарын бохирдлыг бууруулж, улмаар амьдрах орчны чанарыг дээшлүүлэх боломжтой юм.

Мөн олон нийтийн зүгээс шинэ бүтээн байгуулалт эхлэхээс өмнө төлөвлөлтийн шийдвэрт оролцох замаар хотын хөгжил, алсын харааг хамтран тодорхойлох боломжтой билээ. Үүний нэгэн амжилттай жишээ нь Beatles хамтлагийн хөшөө бүхий талбайд худалдааны зориулалттай барилга барих төслийг эсэргүүцсэн жагсаал 2017 оны 8 дугаар сард болсон явдал. Иргэд барилгын ажлыг зогсоож, Засгийн газрын барилгын салбар хариуцсан нэгжийг авилга авсан хэмээн шүүмжилж, хот төлөвлөлтийн шинэ хуулийг шаардсан юм.

Иймэрхүү байдлаар иргэд, олон нийтийн оролцооны тусламжтайгаар хотын удирдлага, засаглалыг сайжруулах боломжтой. Үүний үр дүнд газар чөлөөлөх, дэд бүтэц, төлөвлөлтийг сайжруулах, чадавхийг бэхжүүлэх, ажиллах хүчнийг зохицуулах зэрэг үр дүнтэй ажлууд хэрэгжих боломж бүрдэх юм.



Дэд бүтэц хомсын улмаас гэр хороолол улам бүр тэлсээр.




ХАУСМАНН

БАЙШИН

"40 мянгатын шар байрнууд" гэгддэг орон сууцнууд нь өнөөгийн тогтвортой хот төлөвлөлтийн шалгуураар авч үзвэл Улаанбаатар хотын хувьд хамгийн сайн жишээ нь юм. Үндэслэл, шалтгааныг дор тодруулъя.

•Хаусманны орон сууцны барилгууд нь одоогийн ногоон барилгынх шиг олон шинж чанарыг өөртөө агуулсан байна.



1853-1870 онд, Францын эзэн хааны тушаалаар Жорж-Евгений Хауссман нь дундад зууны үеийн "эрүүл бус" хорооллуудыг нурааж өргөн чөлөөтэй, задгай талбай бүхий цэцэрлэгт хүрээлэнгээр хүрээлүүлсэн Парис хотын суурийг анх бий болгосноор хотын ландшафтыг бүрэн өөрчилсөн юм.

1850-1914 онд, одоогийн Парис хотын орон сууцны барилгуудын 60 орчим хувь нь баригдсан гэсэн тооцоо бий. Эдгээр нь бүхэлдээ Хауссманы эрин үеэс эхтэй.

Хаусманны барилга хоорондын хот төлөвлөлт нь дараах онцлогуудтай байдаг. Ижил өндөртэй барилгууд, өргөн гудамж, тагтны төмөр хийц, мансардын дээвэр, симметрик фасадууд, байшин дундах өргөн уудам зай талбай, өргөн том цонх, гудамж бүрд тоглоомын талбай, дэлгүүр, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, гудамжны тавилга, хөшөө зэргийг хүртэл бодолцсон нь иргэддээ ээлтэй оролцоотой хотыг бий болгох гол шалгуур нь юм.

Эдгээр архитектурын онцлог нь Парисын орчин үеийн хотын ландшафтыг цогцоор нь бүрдүүлж, өргөн уудам өргөн чөлөөнүүд, дурсгалт барилгууд, архитектурын нэгдмэл хэв маягаараа алдартай хотыг бий болгосон билээ. Хауссманы өв өнөөдөр ч Парисын дүр төрх, сэтгэл татам байдалд нөлөөлсөөр байна.

Хаусманн загвар

Үйлчлэгчийн байр

Оршин суугчид


Дэлгүүрийн хаяг

Дэлгүүрүүд



Эдгээр онцлог, шалгуураас авч үзвэл нэгдүгээр дөчин мянгат нь нийслэл хотын орон сууцны хорооллын анхны барилга байгууламж төдийгүй Франц улсын Хаусманны хот төлөвлөлтийн шинж чанарыг өөртөө агуулсан байна.

Уг хорооллыг 1958-1961 онд ЗХУ-ын тусламжтайгаар 40 мянган м.кв ашигтай талбайд орон сууцны 3-4 давхар орчин үеийн тохилог олон арван байшин (1093 айл)-гаас гадна сургууль, цэцэрлэг, дэлгүүр, цайны газар зэрэг соёл, үйлчилгээний хэд хэдэн барилгын хамт барьж ашиглалтад оруулж байжээ. ОХУ-ын Санкт-Петербург, Москва, Екатеринбург зэрэг хотод мөн л Хаусманны архитектурын нөлөө бүхий зохион байгуулалтууд бий. Үүнээс үзэхэд ЗХУ нь 40 мянгат хорооллыг төлөвлөхдөө яг Хаусманны загвараар буулгаагүй ч гэсэн бага зэрэг өөрчлөн ерөнхий онцлогуудыг шингээн төлөвлөсөн гэж үзэж болохоор байна.



БНМАУ-ын нийслэл Улаанбаатар хот 1990 он

Хаусманны орон сууцны барилгууд нь одоогийн ногоон барилга шиг олон шинж чанарыг өөртөө агуулжээ. Эдгээрээс дурдвал:

- Хауссманы барилгуудыг цаг хугацааны явцад олон төрлийн зориулалтаар өөрчилж, ашиглах боломжтойгоор төлөвлөж, зохион байгуулжээ. Ингэснээр шинэ барилгын эрэлт хэрэгцээг бууруулахад хувь нэмэр оруулж байгаа юм.
- Орон сууцны төв хэсэг нь алхах, нийтийн тээврээр зорчих боломжийг бүрдүүлсэн бөгөөд энэ нь хувийн автомашинаар зорчих хэрэгцээг багасгаж, улмаар нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулахад хувь нэмэртэй болно.
- Хаусманны барилгууд нь байгалийн гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай архитектурын онцлогийг агуулдгаараа эрчим хүчний хэмнэлт гаргахад хувь нэмэр оруулдаг.

Хаусманны барилгын ерөнхий онцлогууд нь:

Агааржуулалт:

Цонх нь агаарын урсгалыг чөлөөтэй дэмждэг архитектурын онцлог, дизайны зарчимд тулгуурласан. Өндөр, өргөн цонхны онцлог нь байгалийн гэрэл нэвтэрснээр өрөөг илүү гэгээтэй саруулхан болгодог. Мөн агааржуулалтыг нэмэгдүүлж, доторх температурыг зохицуулах, агаарын солилцоог сайжруулахад тусалдаг. Өргөн цонх, тагтны хослол нь хотын барилга байгууламжийн гоо зүйн үзэмжийг нэмж, оршин суугчдыг гадаах орчноор хангадаг. Мөн зэргэлдээ барилгууд нь дундаа нарны гэрэл тусах зайтай тул байгалийн гэрэл, агаарыг барилга руу нэвтрэх нэмэлт боломжийг олгодог.

Давхар:

Нэг төрлийн гоо зүйн үзэмжтэй хотын дүр төрхийг бий болгохыг зорьсон. Барилгын өндрийг хязгаарлах нь гудамжинд нарны гэрэл тусах нөхцөлийг бүрдүүлж хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан. Цөөн давхартай барилга нь гал түймрээс урьдчилан сэргийлэх, хянах үүднээс илүү аюулгүй мөн галын хурдан тархалтыг хязгаарлах тул галын тархах эрсдэл бага байдаг. Хүн амын нэлээд хэсэг нь хотын төв хэсэгт ч гэсэн байгалийн гэрэл, агаарыг ашиглах боломжтой байхаар зохион байгуулагдсан.

Дулаан хадгалалт:

Халуун агаар дээшлэх хандлагатай байдаг бөгөөд өндөр таазтай байх нь таазны ойролцоо халуун агаарыг хуримтлуулах боломжийг олгодог. Энэ нь илүү тав тухтай орчныг бий болгодог. Хауссманн барилгуудын мансард дээвэр нь нэмэлт дотоод орон зайг бий болгосноор эрчим хүчний үр ашиггүй байдлын багасгаж, дээврээс дулаан алдагдахаас сэргийлдэг.



ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД АЛХАЖ, ДУГУЙ УНАДАГ ЗАЛУУС НЭМЭГДСЭЭР БАЙНА

Улаанбаатар хотод өдөрт 350–400 мянган автомашин замын хөдөлгөөнд оролцдог. Үүнийг дагаад хотын замын хөдөлгөөн тэг зогсолтод орж нэг автомашин өдөрт дунджаар 2.5 цаг, жилд 35 хоногийг “зам дээр” өнгөрүүлдэг гэсэн тооцоо бий. Тэгвэл нийтийн тээвэр, хувийн унаагаа ашиглахаас гадна алхаж, дугуй унах сонголтыг амьдралынхаа салшгүй нэг хэсэг болгосон залуусын төлөөлөл замын хөдөлгөөнд оролцоход ямар байдаг талаарх сэтгэгдлээ хуваалцаж байна.



П.Номинбилэг:

Хот дотор замын хөдөлгөөнд ямар байдлаар оролцдог вэ. Яагаад энэ сонголтыг хийдэг вэ?

А цэгээс Б цэг хүрэхэд хэр хугацаа орох нь тодорхой байдаг нь амар. Таксигаар явахад, жишээ нь, 5 минут ч явж мэднэ, 50 ч явж мэднэ, тэгэхээр хугацаа тооцоолоход төвөгтэй. Тэгээд мэдээж мөнгө хэмнэнэ.

Алхаж явахдаа хөгжим сонсох, ном унших, хэлний хичээлээ давахын аль нэгийг хийдэг. Ойрд алхангаа ном уншлаа гэж “загнуулаад” багасгасан.

Замын хөдөлгөөнд оролцох зуураа давхар юу хийдэг вэ?

Тэртэй тэргүй утаа ихтэй хотод зам дагуу алхаж таардаг нь хөнөөлтэй юм даг уу. Бусдаар бол зүгээр байдаг даа.

Замын хөдөлгөөнд оролцоход хотын юуг илүүтэй анзаарч, анхаарч хардаг вэ?

Хүмүүсийг ажиглах л дуртай юм уу. Сонсож байгаа хөгжим, цаг агаарын байдал, орчны байдал сүлэлдээд, гоё санагддаг. Ер нь өөртэйгөө өнгөрүүлдэг сайхан мөчүүд байдаг даа. Алхаж байхдаа элдвийг бодохгүй, тайван байдаг даа.



М.Хосбаяр:

Яагаад дугуйгаар хот дотор явахыг сонгосон бэ. Үүнд хэр их хугацааг зарцуулдаг вэ?

Түгжрэлд алдах хугацаа болон дасгал хөдөлгөөнөө бодолцон хотод унадаг дугуйгаар зорчихыг илүүд үздэг. Өдөрт дунджаар 30–45 минутыг замын хөдөлгөөнд оролцоходоо зарцуулдаг.

Дугуйгаар явахад хамгийн хүндрэлтэй санагддаг зүйлс юу вэ?

Замын бордюр, явган зорчигч дугуйн замаар явах, дугуйн хулгай зэрэг нь хүндрэлтэй байдаг. Харин дугуйн зогсоол нэг үеэ бодвол сайн болсон. smartcar.mn шиг дугуйгаа арлын дугаараар нь бүртгэдэг болговол гоё гэж боддог.

Дугуйгаар явахдаа юуг илүүтэй анзаарч хардаг вэ?

Аль болох хойш, урагшаа харж аюулгүй байдлаа л их бодно доо. Зарим газар яалт ч үгүй машин замаар явах шаардлага гардаг. Жолооч нар болон явган зорчигчид дугуйчдыг хөдөлгөөнд төвөгтэй байна гэж харалгүй түгжрэлтэй тэмцэж байгаа баатрууд гэж хараасай.



Б.Назым:

Хот дотор замын хөдөлгөөнд ямар байдлаар оролцдог вэ. Яагаад энэ сонголтыг хийдэг вэ?

Миний хувьд ажил гэр хооронд алхах зайтай байхыг илүү чухалчилдаг. Энэ нь аз жаргалтай байхад нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг гэж нийтлэлээс уншиж байсан. Түгжрэл болон зогсоолын асуудлаас болж алхахыг илүүд үздэг.

Үүнд ихэвчлэн ямар хугацааг зарцуулдаг вэ?

Өдөрт дор хаяж 1 цагаа алхахад зарцуулдаг. Алхах нь зөвхөн очих газраа хүрэх биш мөн дасгал хөдөлгөөн болж өгдөг эрүүл мэндэд ихээхэн тустай юм.

Замын хөдөлгөөнд оролцох зуураа давхар юу хийдэг вэ?

Алхангаа юм бодох, төлөвлөх боломж их олддог. Мөн сонирхолтой подкаст сонсож мэдлэгээ тэлдэг.

Замын хөдөлгөөнд оролцоход хамгийн хүндрэлтэй санагддаг зүйлс юу вэ?

Явган хүний зам дээр хашаа татаад барилга барьдаг, 2 хүн зөрөхөд хэцүү нарийхан замтай, засмал бус шороон зам байх нь элбэг. Мөн Дугуй, скуүтер унсан хүмүүс явган хүний замаар зэрэгцэж явдаг тул тав тухгүй ба мөргүүлэх эрсдэл үүсгэдэг.

Замын хөдөлгөөнд оролцоход хотын юуг илүүтэй анзаарч, анхаарч хардаг вэ?

Явган хүндээ ээлгүй, хүн болгон машинд суугаад түгжрээд хотоо тойрох зориулалттай юм шиг. Шийдвэр гаргагчид аливаа шийдвэр гаргахад нийгмийн эрх ашгийг эн тэргүүнд тавьдаггүй юм байна гэдэг нь илт харагддаг.

Түгжирч явахдаа дараах подкастыг сонсоод явахыг санал болгоё.



Тогтвортой эдийн засгийн талаар ярилцсан дугаарыг санал болгож байна. Нийтээрээ тогтвортой эдийн засгийн талаарх ойлголттой болох хэрэгтэй ингэснээр маш олон боломжууд бий болж ирнэ. Тогтвортой эдийн засгийн ойлголтыг Дарон, Жеймс А

нарын бичсэн "Why nations fail" номыг санал болгож байна. Энэ дээр нийтээрээ амьдрал нь сайжирдаг хүмүүс илүү тогтвортойгоор хөгжиж явдаг, жишээлбэл баялгийн хувиарлалт нь зөв хийгддэг талаар АНУ, Мексикийн жишээг бид харж болно.

9 сар гарснаас хойш дэлхийн 10 улс үерийн аюулын нөхцөл байдалтай нүүр тулгараад байгааг мэдсэн үү? Харин Монголд Улаанбаатар хот гэлтгүй 7 аймгийн 57 сум тог цахилгаангүй болж, дэд бүтэц болон хүний

амь нас, эд хөрөнгөөрөө бид энэ зуны үерээр хохироод үлдсэн билээ. Бид энэ удаа үерийн аюулыг урьдчилан мэдээлэгч бот хөгжүүлсэн Тесла компанийн баттерей, цахилгаан моторны дата инженер Э.Жавхлантай ярилцлаа.



"Wall Street Journal"-ын 2020 оны шилдэг номын зохиогч, Пулицерын шагналт, эдийн засгийн түүхч, эрчим хүчний шинжээч Даниел Йергины "Шинэ газрын зураг" номыг онцолж байна. Энэхүү номонд эрчим хүчний шинэ технологиуд, уур амьсгалтай холбоотой асуудлууд улс

орнуудын геополитик гадаад харилцаанд хэрхэн нөлөөлж, эрчим хүчний зах зээл яаж хувьсан өөрчлөгдөж буйг бүх талаар тайлбарласан. Зочдоор О.Баттулга, П.Баасан, З.Хишигсайхан, Б.Базаррагчаа нар тус номыг тоймлон та бүхэнд хүргэж байна.

Гамма агентлагийн гэрэл зурагчин С.Цацралт -Улаанбаатараас ярьж байна.

Зочны талаарх сонирхолтой баримтууд

1. С.Цацралт ЗХУ-ын Эрхүү хотын дээд сургуулийг сэтгүүлч мэргэжлээр төгссөн.
2. "Залуучуудын үнэн", "Үнэн", "Ил товчоо" зэрэг сонинд фото сурвалжлагчаар ажиллаж байсан.
3. "Гамма" мэргэжлийн гэрэл зургийн агентлагийг Л.Ганзориг, Ц.Батзориг зэрэг

нөхөдтэйгээ хамтран 1996 онд үүсгэн байгуулж өнөөг хүртэл тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

4. Тэрээр түүхч Д.Өлзийбаатартай хамтран XIX-XX зууны үеийн Монголын уламжлалт хувцасны хийц загварын түүхэн баримтат гэрэл зургуудаар "Хүрээ гоёл: 1890-1920" гэрэл зургийн цомгийг 2013 онд туурвин гаргажээ.
5. Улаанбаатар хотын музейн захирлаар ажиллаж байв.



©2023 Mongolian Visuals, Antitheziz Atelier
Live From Red Hero - Podcast
@livefromredhero



©2023 Mongolian Visuals, Antitheziz Atelier
Live From Red Hero - Podcast
@livefromredhero

Гуру Медиа компанийн продюсер Ц.Ариунаа -Улаанбаатараас ярьж байна

Зочны талаарх сонирхолтой баримтууд

1. Ц.Ариунаа ЗХУ-д хатуу биеийн физикч мэргэжлээр суралцаж төгссөн.
2. 1997 онд найруулагч Питер Бросенс, Д.Төрмөнх нарын хамтарсан "Нохойн орон" УСК-ын зургийн даргаар ажиллаж киноны салбарт хөл тавьжээ. Сонирхолтой нь түүний гэр бүлийн хүн болох найруулагч, зураглаач С.Бямба тус бүтээлд зураглаачаар ажилласан.

3. "Гуру Медиа" ХХК-ийг Ц.Ариунаа, С.Бямба нар хамтран 2006 онд байгуулсан бөгөөд "Хүсэл шунал" (2010) "Алсын удирдлага" (2013) "Хэвтрийн хүн" (2020) зэрэг хэд хэдэн бүрэн хэмжээний уран сайхны болон баримтат кино туурвисан билээ.
4. Ц.Ариунаа 2002 онд Монголын Урлагийн Зөвлөлийг үүсгэн байгуулсан ба өдгөө 20 жилийн ойгоо тэмдэглэж байна.
5. Түүний аав МУУГЗ зураач Д.Цэрэнпил 1964 оны БНМАУ-ын мөнгөн тэмдэгтийн загварыг зохиосон гэдэг.

Улаанбаатараас ярьж байна



Sustainable Mongol podcast



Дууны инженер: Ч.Энхманлай



Хотын үзэгдэх орчны бохирдол

Үзэгдэх орчны бохирдол буюу Visual Pollution гэх ойлголт байгалийн болон хүний гараар бүтсэн ландшафтын гоо зүйд сөргөөр нөлөөлж буй зүйлсийг нийтэд нь хамруулдаг. Төрөл бүрийн зар сурталчилгаа, үзэмжгүй унжсан кабель утаснууд зэрэг зүйлс нь дэлхийн томоохон хотуудад түгээмэл зонхилдог үзэгдэх орчныг бохирдуулж буй зүйлс юм.

Хэрвээ үзэгдэх орчны бохирдлыг нь цэвэрлэчихвэл хотууд ямар харагдах бол?

Дотоод орчны агаарын чанарын HouseFresh компани дэлхийн найман хотын зургийг авч, үзэгдэх орчны бохирдлыг арилгавал ямар харагдахыг туршиж үзжээ. Үр дүнг нь харьцуулсан зургаар харуулъя. Тэгвэл Улаанбаатар хотыг мөн адил рекламгүй болгоод үзвэл ямар харагдах нь вэ?



Монгол



АНУ





Япон



Энэтхэг



Хонконг





**Sustainable
Mongol**

